



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Аудитын тайлан

АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2017-2020 ОНД НИЙТ 456.1 ТЭРБУМ ТӨГРӨГ ЗАРЦУУЛСАН БОЛОВЧ АГААРЫН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ СТАНДАРТ ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ЗАСГИЙН ГАЗРААС АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2017-2020 ОНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ГАГ/2020/13-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755, цахим хаяг: enkhbold@audit.gov.mn

Аудитын менежер Б.Долгөрсүрэн

Утас: 261805, цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn

Аудитор М.Баяртогтох

Утас: 262451, цахим хаяг: bayartogtokh@audit.gov.mn

Аудитор Б.Анхбаатар

Утас: 262451, цахим хаяг: ankhbaatar@audit.gov.mn

Аудитор Ү.Төгсжаргал

Утас: 262451, цахим хаяг: tugsjargalu@audit.gov.mn

Улаанбаатар хот
2021 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Эрчим хүчний яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Татварын ерөнхий газар, Тавантолгой түлш ХХК-д тус тус хүргүүлэхийг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т даалгасугай.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Л.Оюун-Эрдэнэ/, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо /Н.Уртнасан/, Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд /Н.Тавинбэх/, Татварын ерөнхий газар /Б.Заяабал/, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Ж.Батбаясгалан/, Тавантолгой түлш ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ж.Батбаясгалан/-д тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, тэргүүлэх аудитор /Я.Сарансүх/-т даалгасугай.

5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.



Д.ЗАНДАНБАТ

Z:\Tushaal\2021\EA\in A Tushaal\1020\auditin 3-4\Gaза: 1.Docx

001011101

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	4
Зураг, дүрслэлийн жагсаалт	4
Хүснэгтийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	5
Ерөнхий мэдээлэл	7
БҮЛЭГ 1. АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	8
<i>Хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан зарим арга хэмжээг тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаагүй, хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төлөвлөөгүй байна</i>	<i>8</i>
<i>Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, салбар дундын оролцоог хангаж ажиллаагүйгээс төлөвлөсөн арга хэмжээний 67.8 хувь нь хэрэгжээгүй байна</i>	<i>10</i>
<i>Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо хяналт-үнэлгээний чиг үүргээ хэрэгжүүлдэггүй байна</i>	<i>11</i>
<i>Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хариуцан хэрэгжүүлж буй байгууллагуудын ажлын зохион байгуулалт, салбар хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна</i>	<i>11</i>
<i>Агаарын чанарын үзүүлэлтүүдээс хүхэрлэг хийн агууламжаас бусад үзүүлэлтүүд 2016 он буюу суурь түвшинээс буурсан боловч стандарт хэмжээнд хүрээгүй байна</i>	<i>12</i>
<i>Агаарын бохирдлоос шалтгаалсан өвчлөл 2016 оны буюу суурь түвшинтэй харьцуулахад өөрчлөлт гараагүй байна</i>	<i>13</i>
<i>Агаар, орчны бохирдлыг бууруулах талаар олон улсад хэрэгжүүлсэн сайн туршигуудаас</i>	<i>14</i>
БҮЛЭГ 2. АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ХОЛБООТОЙ ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЭЭГҮЙ, ЗАРИМ БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨРИЙН НУУЦАД ХАМААРУУЛАН ШУУД ГЭРЭЭГЭЭР ХУДАЛДАН АВСАН БАЙНА	18
<i>Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэж буй сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн өртөг борлуулалтын үнээс өндөр байгаагаас улс, орон нутгийн төсөв болон Эрдэнэс Тавантолгой ХК-иас санхүүгийн дэмжлэг авсан байна</i>	<i>18</i>
<i>Нийслэлийн хэмжээнд сайжруулсан түлшний борлуулалтын цэгийг тооцоо, судалгаагүй нэмснээс борлуулалтын урамшууллыг хянаж, баталгаажуулахад хүндрэл үүссэн байна</i>	<i>21</i>
<i>Гэр хорооллын айл өрхөд үзүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн 7,319.4 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг ямар байгууллага хариуцан төлөх нь тодорхой бус байна</i>	<i>22</i>
<i>Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төрийн нууцад хамаарахгүй зарим арга хэмжээг шууд гэрээгээр худалдан авсан нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна</i>	<i>24</i>
<i>Агаар, орчны бохирдолтой холбоотой зарим төлбөр, хураамжийг ногдуулах журам, жишиг хэмжээг тооцох аргачлал байхгүйгээс хуульд заасан орлогууд бүрэн төвлөрдөггүй байна</i>	<i>28</i>
<i>Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна</i>	<i>33</i>
<i>Төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллагууд холбогдох хууль, журмын дагуу хяналт-үнэлгээ хийсэн байна</i>	<i>34</i>
ДҮГНЭЛТ	36
ЗӨВЛӨМЖ	38
ХАВСРАЛТУУД	40
<i>Хавсралт 1. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт</i>	<i>40</i>
<i>Хавсралт 2. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжээгүй арга хэмжээний жагсаалт</i>	<i>42</i>
<i>Хавсралт 3. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний дутуу хэрэгжсэн арга хэмжээний жагсаалт</i>	<i>45</i>

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЕХОБ	Европын хөрөнгө оруулалтын банк
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ОББҮХ	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УИХ	Улсын Их Хурал
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТББ	Төрийн бус байгууллага
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Зураг, дүрслэлийн жагсаалт

Дугаар	Нэр
Зураг 1	Агаарын бохирдлын эх үүсвэрээс гарах ялгарлыг бууруулах загвар үзүүлэлт
Дүрслэл 1	Улаанбаатар хотын гадаад орчны агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2016-2020 он
Дүрслэл 2	Үйлдвэрлэлийн өртөгт эзлэх зардлын судалгаа (хувиар)
Дүрслэл 3	Гэр хорооллын айл өрхөд 2017-2020 онд үзүүлсэн эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн судалгаа
Дүрслэл 4	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын судалгаа (сая төгрөгөөр)
Дүрслэл 5	Хог хаягдлын үйлчилгээний хураамж (сая төгрөгөөр)

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Нэр
Хүснэгт 1	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний судалгаа
Хүснэгт 2	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг жил бүрийн үндсэн чиглэлд тусгасан судалгаа
Хүснэгт 3	Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн судалгаа (тэрбум төгрөгөөр)
Хүснэгт 4	Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн судалгаа (тэрбум төгрөгөөр)
Хүснэгт 5	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа (тоогоор)
Хүснэгт 6	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа
Хүснэгт 7	Гадаад орчны агаар бохирдуулах бодисын жилийн дундаж агууламж
Хүснэгт 8	Улаанбаатар хотын амьсгал, цусны эргэлтийн тогтолцооны өвчин, эмнэлэгт хэвтсэн хүнээр, 2016-2020 он, бодит тоо, 10000 хүн амд
Хүснэгт 9	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнүүд
Хүснэгт 10	Тавантолгой түлш ХХК-ийн орлогын эх үүсвэрийн судалгаа (тэрбум төгрөгөөр)
Хүснэгт 11	Сайжруулсан түлшний 1 тонн тутмын өртгийн тооцоолол (мянган төгрөгөөр)
Хүснэгт 12	“Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрт 2017-2020 онд нийслэлийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн судалгаа (сая төгрөгөөр)
Хүснэгт 13	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын судалгаа (сая төгрөгөөр)
Хүснэгт 14	Агаарын бохирдлын төлбөрийн 2016-2020 оны судалгаа (сая төгрөгөөр)
Хүснэгт 15	Автотээврийн хэрэгслийн 2016-2020 онд төлсөн агаарын бохирдлын төлбөрийн судалгаа (сая төгрөгөөр)
Хүснэгт 16	“Цэвэр агаар сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн судалгаа

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 4 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилтыг дэвшүүлж, дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны санхүүжилт, төсөвт төвлөрүүлэх орлогыг хууль, журмын дагуу бүрдүүлсэн эсэх,
- Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг тооцох, тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн харьяа агентлагууд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, түүний ажлын алба, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, “Төрийн аудит MNS 6817:2020” стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг баримтлан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх Төрийн захиргааны төв байгууллагууд, тэдгээрийн харьяа агентлаг, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Нийслэлийн Засаг дарга, түүний харьяа байгууллагуудын агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асууж тодруулах болон судалгаа авах, тулган баталгаажуулах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, иргэдээс санал асуулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллалаа.

Аудитын явцад нарийн мэргэжил шаардсан асуудлаар шинжээчийн багтай хамтран ажиллаж, зөвлөх үйлчилгээний тайланд тусгагдсан асуудлыг тайланд тусгасан болно.

Аудитад ашигласан шалгуур, үзүүлэлт:

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан төлөвлөсөн шалгуур, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлтэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Агаарын тухай хууль
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль

- УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
- УИХ-ын 2018 оны 02 дугаар тогтоол “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2011 оны 309 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журам”, “Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2012 оны 227 дугаар тогтоолоор баталсан “Агаарын бохирдлын төлбөрөөс бүрэн чөлөөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”, “Агаарын бохирдлын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”
- Засгийн газрын 2016 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн гэр хорооллын өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”
- Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”
- Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
- Засгийн газрын 2018 оны 157 дугаар тогтоолоор баталсан “Гаалийн албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийн жагсаалт”, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2019 оны 461 дүгээр тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхзүйн актууд, тайлан мэдээнүүд.

Хүндрэл бэрхшээл:

Аудитын талбарын үе шатны ажлын явцад Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор бүх нийтийн бэлэн байдлын болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээр шалгагдагч байгууллага дээр очиж баримт материалтай танилцах, шаардлагатай баримт материал, судалгааг цахимаар авахад хугацаа алдах, хүлээлт үүсэх, цахимаар авсан баримтууд шаардлага хангахгүй байх, ажил хариуцсан албан хаагчид ажлаас гарснаас зарим баримт, судалгаа авах боломжгүй болох зэрэг эрсдэл үүссэн болно.

Аудитын материаллаг илрүүлэлт:

Аудитаар нийт 43.7 тэрбум төгрөгийн 19 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 10.9 тэрбум төгрөгийн 4 албан шаардлага, 32.8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өглөө.

Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал:

Аудитын явцад 10.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн боловч зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авч ажиллаагүй тул тус асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн¹ 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасныг баталгаажуулах зорилгоор УИХ-аас анх 1995 онд баталсан “Агаарын тухай хууль”-ийг 2010, 2012 онд тус тус шинэчлэн баталж, 2013-2016 онд нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Агаарын тухай хуулийн 2 дугаар бүлэгт агаар хамгаалах талаарх УИХ, Засгийн газар, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийтлэг эрх, үүргийг зааж өгсөн байна.

Монгол Улс болон Улаанбаатар хотын хэмжээнд сүүлийн жилүүдэд агаарын бохирдолтой зэрэгцэн хөрс, усны бохирдол маш их хэмжээгээр ихэссэн тул Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс агаар, ус, хөрсний бохирдол гамшгийн хэмжээнд хүрсэн гэж үзэн холбогдох байгууллагуудад 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 03-03 дугаар зөвлөмжийг өгчээ.

Тус зөвлөмжийн 2.3-т “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог шинэчлэн зохион байгуулж (Орчны бохирдлын асуудлаарх онцгой байдлын үндэсний хороо) онцгой байдлын горимоор ажиллуулах” гэж заасныг үндэслэн Ерөнхий сайдын 2017 оны 51 дүгээр захирамжаар Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог шинэчлэн зохион байгуулсан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3² (2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр баталсан шинэчилсэн найруулгаас өмнөх), Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1³, Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1⁴ дэх заалт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх” зорилтыг дэвшүүлэн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна.

Тус хөтөлбөр нь “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх” зорилготой.

Хөтөлбөрийг 2017-2019 он, 2020-2025 он гэсэн 2 үе шатаар хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийг 2016 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь болгон ашиглаж, 25 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тусгасан байна.

¹ Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ

² Энэ хуулийн 10.2-т заасан жагсаалтад орсон үндэсний хөтөлбөрийг төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна

³ байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

⁴ агаар хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг батлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах

БҮЛЭГ 1. АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1. Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн зорилгыг хангахын тулд дараах 5 зорилтын хүрээнд нийт 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 1. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний судалгаа

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо
1	Хот төлөвлөлт, байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх замаар төвлөрлийг сааруулан хот, суурин газрын агаар, орчны чанарыг сайжруулах	14
2	Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах	17
3	Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах	7
4	Агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт, санхүүжилтийг тодорхой болгож, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг урамшуулах тогтолцоог бий болгох	9
5	Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх	11
НИЙТ		58

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”

1.2. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн А/107 дугаар тушаалаар “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан бөгөөд тус төлөвлөгөөнд дээрх 5 зорилтын хүрээнд 199 шалгуур үзүүлэлт бүхий арга хэмжээг 25 төрийн захиргааны төв байгууллага, агентлаг хариуцан гүйцэтгэхээр төлөвлөжээ.

Хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан зарим арга хэмжээг тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаагүй, хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төлөвлөөгүй байна

1.3. Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайд, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон.

1.4. Тус хөтөлбөр, төлөвлөгөөнд 2017-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 199 арга хэмжээг 25 төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар хариуцан хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн боловч Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга хот байгуулалтын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /хуучин нэрээр/, Зам тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрчим хүчний яамнаас бусад яам, агентлагууд хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх тухайн жилийн үндсэн чиглэлд тусгаагүй байна.

Хүснэгт 2. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг жил бүрийн үндсэн чиглэлд тусгасан судалгаа

Баримт бичгийн нэр	Тусгасан арга хэмжээний тоо	хувиар
Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	10	5.1
Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	19	9.6
Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	14	7.1
Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	15	7.6
Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	20	10.1

Эх үүсвэр: Аудитын судалгаа

1.5. Үндэсний аудитын газраас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр тухайн жилийн үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг судалж үзэхэд дараах байдалтай байна.

- 2017 онд тусгасан 10 арга хэмжээний 100 хувь хэрэгжсэн 1, 70 хувь хэрэгжилтэй 4, огт хэрэгжээгүй 5,
- 2018 онд тусгасан 19 арга хэмжээний 100 хувь хэрэгжсэн 1, 70 хувь хэрэгжилтэй 3, эрчимжүүлэх шаардлагатай 12, огт хэрэгжээгүй 3,
- 2019 онд тусгасан 14 арга хэмжээний 100 хувь хэрэгжсэн 1, 70 хувь хэрэгжилтэй 6, эрчимжүүлэх шаардлагатай 6, огт хэрэгжээгүй 1.

1.6. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 20 арга хэмжээг хэрэгжүүлж, хүрэх түвшнийг 14 үзүүлэлтээр дүгнэхээр тусгажээ.

1.7. Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан Нийслэлийн Засаг даргын хариуцан хэрэгжүүлэх 45 арга хэмжээнээс Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 17/10 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө”-нд 32 арга хэмжээг нь тусгасан байна.

1.8. Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг баталснаас хойш 1 жил 3 сарын дараа Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг баталснаас тус хөтөлбөрт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа хойшилж, нийслэлийн хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 28.9 хувийг нь мастер төлөвлөгөөнд тусгалгүй орхигдуулжээ.

1.9. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 6.1-д “Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, ажлыг дараах⁵ эх үүсвэрээс санхүүжүүлнэ” гэж заасныг үндэслэн 2017-2019 онд агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр улсын төсвөөс 273.1 тэрбум төгрөг, Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк, Дэлхийн банк, БНХАУ-ын зээлээр 168.9 тэрбум төгрөг, Нийслэлийн төсвөөс 14.1 тэрбум төгрөг, нийт 456.1 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

⁵ 6.1.1 улсын болон орон нутгийн төсөв;
6.1.2 агаар бохирдуулсны төлбөрийн орлого;
6.1.3 ус бохирдуулсны төлбөрийн орлого;
6.1.4 олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
6.1.5 аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;
6.1.6 бусад эх үүсвэр.

Хүснэгт 3. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн судалгаа (тэрбум төгрөгөөр)

Санхүүжилтийн эх үүсвэр	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт дүн
Нийт дүн	98.4	74.6	221.7	61.4	456.1
Улсын төсөв	65.8	24.6	124.2	58.5	273.1
Нийслэлийн төсөв	4.4	3.2	4.9	1.6	14.1
Гадаад зээл	28.2	46.8	92.6	1.3	168.9
АХБ, ЕХОБ-ны зээл	8.8	34.0	87.3	0.0	130.1
Дэлхийн банкны зээл	3.5	3.9	2.5	1.3	11.2
БНХАУ-ын зээл	15.9	8.9	2.8	0.0	27.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

1.10. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, Нийслэлийн Засаг даргаас бусад хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд жил бүрийн улсын төсөвт төлөвлөдөггүй байна.

Хүснэгт 4. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн судалгаа (тэрбум төгрөгөөр)

Санхүүжилтийн эх үүсвэр	2017 он		2018 он		2019 он		2020 он	
	төлөвлө гөө	гүйцэт гэл	төлөвлө гөө	гүйцэт гэл	төлөвлө гөө	гүйцэт гэл	төлөвлө гөө	гүйцэт гэл
Нийт дүн	81.8	98.4	34.1	74.6	139.0	221.7	82.5	61.4
Улсын төсөв	76.7	65.8	30.6	24.6	133.9	124.2	80.6	58.5
урсгал зардал	5.0	4.4	16.9	10.9	75.2	69.7	77.3	58.3
хөрөнгө оруулалт	71.7	61.4	13.7	13.7	58.7	54.5	3.3	0.2
Нийслэлийн төсөв	5.1	4.4	3.5	3.2	5.1	4.9	1.9	1.6
урсгал зардал	0.3	0.3	0.4	0.2	0.6	0.6	0.6	0.4
хөрөнгө оруулалт	4.8	4.1	3.1	3.0	4.5	4.3	1.3	1.2

Эх үүсвэр: Сангийн яам, БОАЖЯ, ОББҮХ, НЗДТГ-ын мэдээлэл

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, салбар дундын оролцоог хангаж ажиллаагүйгээс төлөвлөсөн арга хэмжээний 67.8 хувь нь хэрэгжээгүй байна

1.11. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2017-2019 онд буюу хөтөлбөрийн 1 дүгээр үе шатанд 199 буюу бүх арга хэмжээг эхлүүлж, 2017-2020 онд 91 арга хэмжээг дуусгахаар төлөвлөсөн боловч 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хэрэгжилтийг тооцож үзэхэд бүрэн хэрэгжсэн 64, хэрэгжээгүй 46, дутуу хэрэгжсэн 29 арга хэмжээ байна.

Хүснэгт 5. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа (тоогоор)

Зорилтын дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжсэн арга хэмжээ Үүнээс:			Хэрэгжээгүй арга хэмжээ		Дутуу хэрэгжсэн арга хэмжээ	
		Нийт	2017-2020 онд бүрэн хэрэгжсэн	Он дамжин хэрэгжиж байгаа	Нийт	Хэрэгжилт ирүүлээгүй	Хэрэгжих хугацаа дууссан	Хэрэгжих хугацаа дуусаагүй
1	58	28	17	11	15	8	5	10
2	60	39	20	19	18	3	2	1
3	29	18	7	11	7	1	1	3
4	23	13	11	2	4	2	5	1
5	29	26	9	17	2	1	0	1
Дүн	199	124	64	60	46	15	13	16
Нийт арга хэмжээнд эзлэх хувь		62.3			23.1		14.6	

Эх сурвалж: Аудитын судалгаа

1.12. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний 62.3 хувь нь хэрэгжсэн, 23.1 хувь нь хэрэгжээгүй, 14.6 хувь нь дутуу хэрэгжилттэй буюу хэрэгжих шатандаа байгаа тул тус хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, салбар хоорондын ажлын уялдааг хангаж ажиллах шаардлагатай байна. (Хавсралт 2, 3)

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо хяналт-үнэлгээний чиг үүргээ хэрэгжүүлдэггүй байна

1.13. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах чиг үүргээ биелүүлдэггүй байна.

Хүснэгт 6. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа

№	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Хэрэгжүүлсэн эсэх			
		2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг жил бүр мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран гүйцэтгэнэ.	үгүй	үгүй	үгүй	үгүй
2	Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	үгүй	үгүй	үгүй	үгүй
3	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт танилцуулна.	үгүй	үгүй	үгүй	үгүй

Эх үүсвэр: Аудитын судалгаа

1.14. Хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнаагүйгээс хөтөлбөр хангалтгүй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах, сайжруулах боломжийг алдсан байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хариуцан хэрэгжүүлж буй байгууллагуудын ажлын зохион байгуулалт, салбар хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна

1.15. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргээ биелээгүйгээс Засгийн Газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үр нөлөө буурах нөхцөл бүрдсэн байна.

1.16. Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх Төрийн захиргааны төв байгууллагууд, нийслэл, орон нутгийн байгууллагууд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг хангалттай зохион байгуулаагүй байна.

1.17. Агаар, орчны бохирдлыг бууруулах бодлого, чиглэлээр хангах, үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай, орон тооны албан хаагчидтай бие даасан зохион байгуулалтын нэгж байхгүй байна.

1.18. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүтэц, зохион байгуулалт нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын дэргэд орон тооны бус албан хаагчидтай, ажлын

албаны хэлбэрээр байнгын үйл ажиллагаа явуулж байгаа нь салбар дундын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлж чадахгүй байна.

Агаарын чанарын үзүүлэлтүүдээс хүхэрлэг хийн агууламжаас бусад үзүүлэлтүүд 2016 он буюу суурь түвшинээс буурсан боловч стандарт хэмжээнд хүрээгүй байна

1.19. Улаанбаатар хотын гадаад орчны агаар бохирдуулах бодисын 2020 оны жилийн дундаж агууламжийг⁶ 2016 онтой харьцуулахад PM2.5 тоосонцор 30 мкг/м³, PM10 тоосонцор 38 мкг/м³-ээр, Азотын давхар исэл (NO₂) 1 мкг/м³-ээр багассан, харин хүхэрлэг хий (SO₂) 11 мкг/м³-ээр ихэссэн байна.

Хүснэгт 7. Гадаад орчны агаар бохирдуулах бодисын жилийн дундаж агууламж


Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS4585:2016	Жилийн дундаж агууламж				
		2016	2017	2018	2019	2020
PM2.5 тоосонцор	25 мкг/м ³	79	86	74	60	49
PM10 тоосонцор	50 мкг/м ³	128	132	136	124	90
Азотын давхар исэл NO ₂	40 мкг/м ³	38	39	34	38	37
Хүхэрлэг хий SO ₂	20 мкг/м ³	36	24	25	29	47

Эх үүсвэр: Зөвлөхийн үйлчилгээний тайлан

1.20. Дээрх хугацаанд азотын давхар ислийн жилийн дундаж агууламж Монгол Улсын стандарт болон ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнд байгаа боловч дараах бохирдуулах бодисууд өндөр хэвээр байна.

- Хүхэрлэг хийн агууламж 2016 онд стандартаас 1.8 дахин их, 2020 онд жилийн дундаж агууламж 47 мкг/м³ болж Монгол Улсын стандарт болон ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 2.4 дахин өндөр;
- PM10 тоосонцрын 2016 оны жилийн дундаж агууламж 128 мкг/м³ буюу Монгол Улсын стандартаас 2.6 дахин их, ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 6.3 дахин өндөр байсан бол 2020 онд 90 мкг/м³ болж буурсан ч Монгол Улсын стандартаас 1.8 дахин их, ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 4.5 дахин өндөр;
- PM2.5 тоосонцрын 2016 оны жилийн дундаж агууламж 79 мкг/м³ буюу Монгол Улсын стандартаас 3.16 дахин их, ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 3.95 дахин өндөр байсан бол 2020 онд 49 мкг/м³ болж буурсан ч Монгол Улсын стандартаас 1.9 дахин их, ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 2.45 дахин өндөр.

1.21. **Хүхэрлэг хий (SO₂).** 2020 онд SO₂ -ын сарын дундаж агууламж 11, 12, 1, 2 дугаар сард MNS4585:2016 стандартаас давсан, 12 дугаар сард хамгийн өндөр буюу стандартаас 4.2 дахин давсан үзүүлэлттэй байна. Түүхий нүүрс хэрэглэж байсан 2016 онд 12, 1, 2, 2017-2018 онд 1, 2, 2019 онд 11, 12, 2020 оны 1 дүгээр саруудад тус стандартаас давсан үзүүлэлттэй байсан байна. SO₂-ын үзүүлэлт 2016 оны 12 дугаар сард 76 мкг/м³, 1 дүгээр сард 101 мкг/м³ байсан бол 2020 онд 211 мкг/м³, 120 мкг/м³ болж, 1.1-2.7 дахин өсжээ.



Дүрслэл 1. Улаанбаатар хотын гадаад орчны агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2016-2020 он

⁶ Тухайн жилийн өдөр бүр эсвэл сараар тооцсон үзүүлэлтийн дундаж агууламжийг хэлнэ.

1.22. 2020 онд PM10, PM2.5-ын сарын дундаж агууламж 12 болон 1 дүгээр сард MNS4585:2016 стандартаас давсан үзүүлэлттэй байсан бол түүхий нүүрс хэрэглэж байсан 2016-2019 онд 10, 11, 12, 1, 2, 3 дугаар саруудад тус тус стандартаас давсан үзүүлэлттэй байв. (Дэлгэрэнгүй тайланг Зөвлөх үйлчилгээний тайлангаас үзнэ үү)

Агаарын бохирдлоос шалтгаалсан өвчлөл 2016 оны буюу суурь түвшинтэй харьцуулахад өөрчлөлт гараагүй байна

1.23. Улаанбаатар хотод 2016-2020 онд амьсгалын замын тогтолцооны өвчний улмаас 1688, зүрх судасны тогтолцооны өвчний улмаас 10940 хүн нас барсан байна. Цусны эргэлтийн тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 10000 хүн амд 2020 онд 15.0 болж, 2016 оноос 0.5-аар өссөн бол амьсгалын замын тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 2020 онд 2.1 болж 0.3-аар буурсан байна.

1.24. Судлагдсан хугацаанд 10,000 хүн амд ногдох уушгины хатгалгаа 0.3, цусны даралт ихсэх 0.2, зүрхний шигдээсний шалтгаант нас баралт 0.1-ээр тус тус буурсан, уушгины хавдрын шалтгаант нас баралт 0.3-аар нэмэгдсэн байна. Үүнээс үзвэл, өвчлөл, нас баралтын тоо хэмжээний үзүүлэлтэд дорвитой өөрчлөлт гараагүй байгаа нь агаарын бохирдлын нөлөө үргэлжилсээр байгааг илтгэж байна.

1.25. Амьсгалын замын болон цусны эргэлтийн тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 1 дүгээр сард хамгийн өндөр бүртгэгдсэн байна. Энэ үзүүлэлт 2016-2018 онд ихэнх саруудад өсөж, 2019 оноос буурах дүр зураг ажиглагдаж байгаа ч энэ нь агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй шууд хамааралтай гэж үзэх боломжгүй юм.

1.26. Улаанбаатар хотод 2020 онд хийсэн судалгаагаар 2016 он буюу суурь оноос 10000 хүн амд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн томуу ба уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралт 2.7-оор, 25-аас дээш насны хүн амын даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт 3.5-аар тус тус буурсан, харин уушгины архаг бөглөрөлт өвчний шалтгаант нас баралт 0.1-ээр, уушгины хавдар 0.6-аар, зүрхний шигдээс 0.2-оор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Нас баралтын дүнд дорвитой өөрчлөлт гараагүй нь агаарын бохирдлын сөрөг нөлөө хэвээр үргэлжилсээр байгааг харуулж байна.

Орчны бохирдлоос шалтгаалсан нас баралтын талаар:

- Амьсгалын тогтолцооны өвчин 10000 хүн ам тутамд 2016 онд 479.9 байсан бол 2019 онд 504.5 болон нэмэгджээ.
- Зүрх судасны тогтолцооны өвчлөл 10000 хүн ам тутамд 2016 онд 356.3 байсан бол 2019 онд 376.1 болон нэмэгджээ.

Хүснэгт 8. Улаанбаатар хотын амьсгал, цусны эргэлтийн тогтолцооны өвчин, эмнэлэгт хэвтсэн хүнээр, 2016-2020 он, бодит тоо, 10000 хүн амд

Судлагдсан хугацаа	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин		Амьсгалын тогтолцооны өвчин	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
2016 он	47393	356.3	63834	479.9
2017 он	49573	354.3	64215	459.0
2018 он	52730	368.5	70246	490.9
2019 он	54797	376.1	73499	504.5

Эх сурвалж: Нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн үзүүлэлт 2019

Агаар, орчны бохирдлыг бууруулах талаар олон улсад хэрэгжүүлсэн сайн туршлагаудаас

1.27. Дэлхийн улс орны агаар бохирдуулагч эх үүсвэрүүд ялгаатай байдаг бөгөөд түүнд тохирсон ялгарлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг тул олон улсад хэрэгжүүлсэн сайн туршлага бүхэн манай улсад тохирно гэж үзэж болохгүй юм.

1.29. Олон улсын эрчим хүчний агентлаг нь цэвэр эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний болон салбарын хэмжээнд гарч буй ахиц дэвшлийг тандан судалдаг бөгөөд тус агентлагийн мэдээгээр “цэвэр эрчим хүчний зорилтуудад хүрэхийн тулд тодорхой зорилт дэвшүүлж, түүнд хүрэх эрчимтэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай” гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 9. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнүүд

	Гадаад орчны агаарын бохирдол	Дотоод орчны агаарын бохирдол
Богино хугацааны арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> Гол бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх; бохирдлын суурин эх үүсвэрт чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх, тоосжилт бууруулах систем суурилуулах; хяналт-шинжилгээний тогтолцоо бий болгох; түлш ба хөдөлгүүрийн чанарыг сайжруулах стандарт хэрэгжүүлэх; хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үр дүнтэй механизм бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> Одоо хэрэгжүүлж буй арга хэмжээ (цэвэр түлш, сайжруулсан зуух)-г үнэлж, өргөжүүлбэл зохих стратегийг тодорхойлох, Сургалт, сурталчилгааны компаниг ажил зохион байгуулах; Амжилттай хэрэгжиж буй шийдлүүдэд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх
Дунд хугацааны арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> Тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлагыг тодорхойлж, үзлэгийн цэгүүдийг байгуулах; Цахилгаан ба гибрид тээврийн хэрэгсэл ашиглах хөшүүрэг бий болгох; Нийтийн тээврийг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> Цэвэр түлш, сайжруулсан зуухны хүртээмжийг нэмэгдүүлэх; Халаалт, хатуу түлшээр ажилладаг бусад системийн шийдлийг оновчтой болгох
Урт хугацааны арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> Гудамж, замын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх; Явган хүний болон дугуйн зам байгуулж идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих; Тээврийн хэрэгслээр зорчихоос аль болох татгалзах механизм бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> Цэвэр түлшийг бүх нийтэд хүртээмжтэй болгох
Бодлого ба хэрэгжүүлэх дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> Орчны бохирдолд хамгийн их хувь нэмэр оруулж буй эх үүсвэрүүдийг тодорхойлох; Бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэл, зорилт, хэрэгжүүлэх хугацааг тогтоох; Салбар хоорондын өндөр түвшний зохицуулах зөвлөл байгуулах; Олон нийт, иргэний нийгмийн оролцоог хангах 	<ul style="list-style-type: none"> Зорилтот хүн амыг тодорхойлох; Хариуцах засгийн газрын байгууллагыг тодорхойлох; түлшийг орлуулах буюу сайжруулах хэрэгжих боломжтой стратеги боловсруулах; Санхүүгийн хөшүүрэг бий болгох
Чадавч бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Үндсэн бохирдуулагч бодис ба эх үүсвэрийг зохих ёсоор хянах; Бохирдлын эх үүсвэрүүдийн орчны бохирдолд оруулж буй хувь нэмрийн талаар ойлголт бий болгох; Тээврийн хэрэгслийн үзлэгийн цэгүүдийн үйл ажиллагааг дэмжих 	<ul style="list-style-type: none"> Хяналтын механизм байгуулах; орон нутгийн дистрибьютер, үйлчилгээ үзүүлэгч нарт дэмжлэг үзүүлэх
Бүтцийн тулгамдсан асуудал	<ul style="list-style-type: none"> Дагуул хотуудыг өргөжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Халаалтад хатуу түлш хэрэглэх явдлыг бууруулах буюу хориглох

1.30. Дээрх хүснэгтээс харахад агаарын бохирдлыг бууруулахад олон салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, бүх талын арга хэмжээг авах шаардлагатай болж байна.

Ялгарлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн сайн туршлагауд:

1.31. БНХАУ-ын Засгийн газар Бээжин хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр “нүүрснээс хийн түлш рүү” бодлогыг 2013 оноос эхлэн хэрэгжүүлснээс хойш жилийн дараа буюу 2014 онд агаарын чанарын индексийг 10.79, SO₂-ийг 12.08, NO₂-ийг 4.89, PM10-ийг 13.07, PM2.5-ийг 11.94, азотын давхар ислийг 11.10 хувиар бууруулсан байна.⁷

1.32. Тус бодлогын хүрээнд айл өрхийн нүүрс, хатуу түлшний хэрэглээг халж, хийн түлшний хэрэглээг нэвтрүүлснээр БНХАУ-ын эрчим хүчний цэвэр эх үүсвэр (сэргээгдэх ба цөмийн эрчим хүч)-ийн хэрэглээг 2010 онд 9.4 хувь байсныг 2015 онд 11.4 хувьд хүргэх зорилгоо давуулан 12 хувь болгон өсгөж, урт хугацааны төлөвлөгөөнд эрчим хүчний цэвэр эх үүсвэрийн хэрэглээг 2020 он гэхэд 15-аас доошгүй хувь, 2030 он гэхэд 20-оос доошгүй хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн байна.⁸

1.33. Гана улсын айл өрхүүдийн 95 хувь нь 2000 онд хатуу түлш хэрэглэдэг байсан нь хойд Африкийн бусад улсын дундаж (73.4 хувь)-аас нэлээд өндөр үзүүлэлт байв. Үүнийг шийдвэрлэхийн тулд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаас түлшний үр ашгийг дээшлүүлэх зорилгоор 2002 оноос нүүрс түлдэг уламжлалт зуухыг керамик доторлогоотой сайжруулсан зуухаар орлуулах төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд сайжруулсан зуух нь уламжлалт зуухнаас 50-60 хувиар бага түлш хэрэглэж, утааны ялгаралтыг мөн бууруулжээ.

1.34. Тус төсөл нь орон нутагт сайжруулсан зуух үйлдвэрлэх үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр шинээр бий болгосон давхар үр өгөөжтэй байсан бөгөөд 2008 онд нийт 68.0 мянган ширхэг зуух зарж, 400.0 мянган хүн, түүний дотор ойролцоогоор 160.0 мянган хүүхдийг гэр доторх цэвэр агаараар хангах боломжтой болж, агаарт байгаа PM10 тоосонцрын 24 цагийн дундаж агууламж 40-45 хувиар буурсан, 5 хүртэлх насны хүүхдүүд амьсгалын замын өвчнөөр нас барах магадлал 25 хувиар багассан байна.

1.35. Энэтхэг Улс 2016 онд газрын тосны үндэсний компаниудаар дамжуулан 3 жилийн дотор 50.0 сая ядуу өрхийг шингэрүүлсэн хийгээр хангах зорилт тавьж, “Татгалз” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, дундаж орлоготой айл өрхүүдийг шингэрүүлсэн хий ашиглахыг уриалж, компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд хөтөлбөрийн зардлыг санхүүжүүлж, тус хөтөлбөрт 10.0 сая гаруй өрхийг хамруулсан байна.

1.36. Энэтхэгийн Байгаль орчин, ойн яам нь 1990-ээд оны сүүлчээр автомашинаас агаарт хаягдах агаар бохирдуулагч бодисуудыг бууруулахын тулд байгалийн хийн түлшээр ажилладаг автобусны хэрэглээг нэвтрүүлэх, хяналт үзлэг, засвар үйлчилгээний зайлшгүй болон яндангаас ялгарах бодисын нормд хатуу шаардлага боловсруулж, бохирдлын татварыг нэмэгдүүлэх зэргээр өргөн цар хүрээтэй арга хэмжээ авчээ.

1.37. Дели дэх байгалийн хийн хэрэглээний амжилт нь орон нутгийн засаг захиргаа, хувийн компаниуд болон хувь хүмүүсийг цэвэр түлш рүү шилжүүлэхээр албадсан хууль ёсны шаардлагад үндэслэсэн бөгөөд Энэтхэгийн захиргааны байгууллагууд яндангаас ялгарах бодисын норм, заавал хийх үзлэг болон засвар үйлчилгээний шаардлагыг нэвтрүүлж, хувийн хуучин тээврийн хэрэгслүүдийг хэрэглээнээс аажмаар гаргажээ.

⁷Zhe Liu & Xueli Chen & Jinyang Cai & Tomas Baležentis & Yue Li, 2020. "The Impact of "Coal to Gas" Policy on Air Quality: Evidence from Beijing, China," *Energies*, MDPI, Open Access Journal, vol. 13(15), pages 1-11, July.

⁸How China's 13th Five-Year Plan Addresses Energy and the Environment <https://www.chinafile.com/reporting-opinion/environment/how-chinas-13th-five-year-plan-addresses-energy-and-environment>

1.38. Борлуулалтын татвараас чөлөөлөх болон бусад урамшуулал олгох замаар Дели хотын захиргаа 47.0 мянган хуучин тээврийн хэрэгслийг солиход тусалсан байна. Мөн 2005 оноос эхлэн дизель түлшээр ажилладаг автобусанд агаарын бохирдлын татвар ногдуулан хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлсэн хуулийн хатуу шаардлага нь сайн үр дүнд хүргэсэн бөгөөд тээврийн хэрэгслийн болон агаарын гол бохирдуулагч бодисын хэмжээ буурч эхэлсэн байна. Тухайлбал:

- 1998-2003 оны хооронд нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) 50 хувиар;
- 1993-2000 онд хар тугалга 75 хувиар тус тус буурчээ.


1.39. 2000-2003 онд автобусыг байгалийн хийгээр ажилладаг болгосны дараа хүхрийн давхар исэл (SO₂) 34.8 хувиар, тоосонцор (PM₁₀) 7 хувиар буурсан боловч энэ хугацаанд азотын давхар исэл (NO₂) 13.7 хувиар өссөн байна.

1.40. Энэ нь хувийн тээврийн хэрэгслийн огцом өсөлт болон уламжлалт хөдөлгүүртэй харьцуулахад байгалийн хийгээр ажилладаг автомашины азотын давхар исэл NO₂-ын ялгаруулалтын түвшин өндөр байдагтай холбоотой байж болно гэж тус улсын судлаачид таамагласан байна.

1.41. Дели хот агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр эрчимтэй хүчин чармайлт гаргасны үр дүнд АНУ-ын Эрчим хүчний яамнаас “Цэвэр хотууд” олон улсын шагнал хүртсэн байна.

1.42. Агаарын бохирдлыг бууруулахдаа дараах загварын дагуу бохирдлын эх үүсвэрээс гарах ялгарлыг бууруулах 5 үзүүлэлтийг харгалзан үзэх шаардлагатай юм.

Зураг 1. Агаарын бохирдлын эх үүсвэрээс гарах ялгарлыг бууруулах загвар үзүүлэлт



Эх сурвалж: Зөвлөх үйлчилгээний тайлан

1.43. Хотын хүн амын өсөлт, нийгэм-эдийн засгийн хөгжил, технологийн дэвшил нь өөрөө агаарын бохирдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйлийн нэг юм.

1.44. Монгол Улсад 2019 оны байдлаар хүн амын нягтрал 1 км² талбайд 2.1 хүн ногдож байгаа боловч Улаанбаатар хотод 312.6 хүн буюу хамгийн өндөр нягтралтай байна. Монгол

Улсын нийт хүн амын тоо 2019 онд 3,296,866 байгаагаас Улаанбаатар хотод 2,258,866 хүн амьдарч байна.

1.45. Энэ нь хөдөө орон нутагт ажил эрхлэх боломж хязгаарлагдмал байгаагаас хот уруу шилжих хөдөлгөөн, хот суурин газрын хүн амын өсөлт ихэссэнтэй холбоотой юм.

1.46. Мөн төлөвлөлт, хяналтгүйгээр хотжилт хурдацтай хөгжиж, төлөвлөлтгүй орон сууцны хороолол баригдах, үйлчилгээ үзүүлж буй газруудад хэт их ачаалал үүсэх, түүнээс шалтгаалан эрүүл ахуй, агаарын бохирдол, ундны усны хангалтгүй байдал, хүн амын хэт их төвлөрөл үүсэх зэрэг нийгмийн асуудлууд олноор бий болж, дарамт үүсгэж байна.

1.47. Хотжилт нь хүрээлэн буй орчны эрүүл мэндийн чухал хөдөлгөгч хүчин болдог тул агаарын бохирдлыг бууруулах зорилтдоо хүрэхийн тулд Их Британи Улсын жишгээр нийслэл, дүүргийн агаарын чанарын менежментийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай юм. *(Зөвлөх үйлчилгээний тайлангаас бусад сайн туршиллагуудыг үзнэ үү)*

1.48. Аймаг, нийслэл, дүүргийн удирдлагууд агаарын чанарыг стандартын түвшинд хүргэх үүрэг хүлээж, өөрийн орон нутагт зохицуулалт хийх эрх бүхий механизм, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, жил бүр агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах, тайлагнах, үр дүнг үнэлэх, шаардлагатай тохиолдолд орон нутгийн удирдлагууд агаарын чанарын бүс, газруудыг зарлах, орон нутгийн онцлогт тохирсон агаар, орчны бохирдлыг бууруулах бодлого, үйл ажиллагааны хөтөлбөртэй байх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.49. Одоогийн тогтолцоогоор нийслэлд агаарын бохирдлыг бууруулах асуудал хариуцсан нэгж ажиллаж байгаа боловч дүүргийн удирдлагууд өөрийн нутаг дэвсгэр дээрх агаарын чанарыг сайжруулахад ямар ч үүрэг хүлээхгүй байна.

1.50. Агаарын бохирдлыг бууруулахын тулд түүхий, сайжруулсан аль ч төрлийн органик түлшнээс татгалзаж, нарны буюу салхины сэргээгдэх цэвэр эрчим хүчний эх үүсвэр, дэвшилтэт технологийг хөгжүүлэх ажлыг хурдавчлах нь зүйтэй юм.

1.51. Айл өрхүүдийг хий, био-хийн түлш, эрчим хүчний цэвэр эх үүсвэр ашиглан гаргаж авсан харьцангуй хямд цахилгаанаар хангах замаар нүүрс, мод түлэхийг багасгаж, агаарын бохирдлыг бууруулах боломжтой байна.

1.52. Ойрын хугацаанд гэр хорооллын 200.0 мянган өрхийн яндангийн тоог бууруулах боломжгүй тул цаашид нэмэхгүй байх, одоогийн ашиглаж буй сайжруулсан түлшний хүхрийн давхар ислийн ялгарлыг бууруулах боломжийг судалж, түлшний чанарыг сайжруулах шаардлагатай байна. *(Зөвлөх үйлчилгээний тайлангаас бусад сайн туршиллагуудыг үзнэ үү)*

БҮЛЭГ 2. АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ХОЛБООТОЙ ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЭЭГҮЙ, ЗАРИМ БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨРИЙН НУУЦАД ХАМААРУУЛАН ШУУД ГЭРЭЭГЭЭР ХУДАЛДАН АВСАН БАЙНА

2.1. Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж, сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх, агаарын чанарын бүсэд хамаарах айл өрхүүдэд эрчим хүчний орой, шөнийн тарифын хөнгөлөлт олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэж буй сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн өртөг борлуулалтын үнээс өндөр байгаагаас улс, орон нутгийн төсөв болон Эрдэнэс Тавантолгой ХК-иас санхүүгийн дэмжлэг авсан байна

2.2. Улсын Их Хурлын 2018 оны 2 дугаар тогтоолын 4 дэх заалт, “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Засгийн Газрын 2018 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх чиг үүрэг бүхий Тавантолгой түлш ХХК-ийг байгуулжээ.

2.3. Тус компани бусад эх үүсвэр болон өөрийн үйл ажиллагаанаас дараах орлогыг бүрдүүлж, 2019 онд 202.3 мянга, 2020 онд 530.3 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж, борлуулсан байна.

Хүснэгт 10. Тавантолгой түлш ХХК-ийн орлогын эх үүсвэрийн судалгаа (тэрбум төгрөгөөр)

№	Ангилал	2019 он	2020 он	Зориулалт
1	Эрдэнэс тавантолгой ХК-ийн зээлийн санхүүжилт	111.8	138.7	Үйлдвэрийн хөрөнгө оруулалт
2	ОББҮХ-оос олгосон санхүүгийн дэмжлэг	14.1	25.5	Үйл ажиллагааны зардал/үйлдвэрийн хөрөнгө оруулалт
3	НАБТГ-аас олгосон санхүүгийн дэмжлэг	2.3	5.8	Үйлдвэрийн дараах түгээлт, борлуулалтын урамшуулал
Санхүүгийн дэмжлэгийн дүн		128.2	170.0	
1	Борлуулалтын орлого	22.1	57.5	Үйл ажиллагааны зардал
2	Хүүгийн болон бусад орлого	1.0	-	
3	УБТЗ-аас борлуулалтын орлого	-	0.8	
Үйл ажиллагааны орлогын дүн		23.1	58.3	
Нийт дүн		151.3	228.3	

Эх сурвалж: Тавантолгой түлш ХХК-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэл

2.4. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/12 дугаар тогтоолоор сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг түүхий нүүрсний зах зээлийн үнээс хэтрүүлэхгүй байхаар тооцож, 150.0 мянган төгрөгөөр тогтоожээ.

2.5. Коронавируст цар тахал гарснаас шалтгаалан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийслэлийн гэр хорооллын иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор Засгийн Газрын 2020 оны 200 дугаар тогтоолоор сайжруулсан түлшний нэг тонн тутмын үнийг 50 хувь, 2020 оны 211 дүгээр тогтоолоор 25 хувиар, нийт 75 хувиар 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хөнгөлөх шийдвэр гарснаас шалтгаалан Тавантолгой түлш ХХК-ийн борлуулалтын орлого буурч, Эрдэнэс Тавантолгой ХК-д ирээдүйд төлөх өр төлбөр өсөхөөр байна.

2.6. Сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үйлдвэрлэлийн өртгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тооцоход цэвэр⁹ өртөг нь 215.1 мянган төгрөг болж байгаагаас үзэхэд тус үйлдвэр үйлдвэрлэлийн өртөг болон борлуулалттай холбоотой нэмэлт зардлаа нөхөж чадахгүй байна.

Хүснэгт 11. Сайжруулсан түлшний 1 тонн тутмын өртгийн тооцоолол


(тогроогоор)

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ӨРТӨГ		
	Нийт дүн	Нэгж өртөг	Зардлын хувь
Үндсэн шугамын ээлжийн ажилчдын цалин	14,569,783,259	24,150	12.1%
Үндсэн шугамын ээлжийн ажилчдын цалин /ЭМНДШ-АО/	2,273,896,809	3,769	1.9%
Шууд хөдөлмөрийн зардал	16,843,680,068	27,919	14.0%
Мидлинг /тээвэрлэлт/	41,614,710,340	68,978	34.6%
Барьцалдуулагч	41,971,644,161	69,570	34.8%
Шуудай	10,361,456,560	17,175	8.6%
Шууд материалын зардал	93,947,811,061	155,723	78.0%
Барилга, Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн элэгдэл	2,196,015,495	3,640	1.8%
Хангамжийн материал	928,647,549	1,539	0.8%
Ашиглалтын зардал	1,996,506,306	3,309	1.7%
Хоолны зардал		-	
Машин механизмын түрээсийн зардал	985,882,456	1,634	0.8%
Үйлдвэрүүдэд ажиллаж буй тээврийн хэрэгсэл, машин механизмын шатахууны зардал	721,869,323	1,197	0.6%
Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тос тосолгооны зардал	323,671,680	537	0.3%
Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал	7,152,592,809	11,856	6.0%
Тайлант үеийн зардал	117,944,083,939	195,498	98.0%
Дуусаагүй үйлдвэрлэлийн эхний үлдэгдэл	2,512,678,975	4,165	2.1%
Нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг /бохир/	120,456,762,914	199,663	100.0%
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ /бохир тонн/		603,302	
Хэвийн хорогдлын тоо хэмжээ /тонн/		18,959	
Нунтаг бүтээгдэхүүний эцсийн үлдэгдэл /тонн/	6,374,073,596	54,064	
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ /цэвэр тонн/	114,082,689,318	530,278	
Нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг /цэвэр/	114,082,689,318	215,138	

Эх сурвалж: Тавантолгой түлш ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайлан мэдээ, түүхий эдийн үлдэгдлийн мэдээ

2.7. Үйлдвэрлэлийн өртөгт хамгийн өндөр буюу 78 хувийг шууд материалын өртөг, 14 хувийг цалин, НДШ-ийн зардал тус тус эзэлж байна.

Дүрслэл 2. Үйлдвэрлэлийн өртөгт эзлэх зардлын судалгаа (хувиар)



Эх сурвалж: “Тавантолгой түлш” ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайлан, мэдээ

⁹ Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон хэвийн хорогдлын тоо хэмжээ, нунтаг бүтээгдэхүүний эцсийн үлдэгдэлийг тооцоонд оруулав.

2.8. Үйлдвэрлэлийн өртөг өндөр байгаа нь дараах хүчин зүйлсээс шалтгаалж байна. Үүнд:

- Барьцалдуулагчийн стандартын шаардлага хангасан дотоодын үйлдвэр байхгүйгээс барьцалдуулагчийг ихэвчлэн БНХАУ-аас худалдсан авснаас 1 тонн тутмын өртөг 1.8 сая төгрөг болсон;
- Тавантолгойн уурхайгаас нүүрсний тээврийг том оврын машинаар тээвэрлэж байгаагаас тээвэрлэлтийн нэгжийн өртөг 68.9 мянган төгрөгт хүрсэн;
- Сайжруулсан түлш савлах стандартын шуудай үйлдвэрлэх дотоодын үйлдвэр байхгүйгээс 25, 100, 1000 килограммын шуудайг ихэвчлэн БНХАУ-аас худалдан авсан.

2.9. Хүний оролцоо багатай автомат савлагааны төхөөрөмж байхгүй, сайжруулсан шахмал түлш нөөцлөх дундын агуулах хүрэлцээгүйгээс үйлдвэр 4 улирлын турш жигд ажиллах боломжгүй болж, дулааны улиралд сайжруулсан шахмал түлшийг хүрэлцэхүйц хэмжээнд үйлдвэрлэж нөөцөлж чадахгүй байна.

2.10. Таван толгой түлш ХХК нийслэлийн баруун бүсэд буюу Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороонд анхны сайжруулсан шахмал түлшний үйлдвэрээ байгуулсан нь тус үйлдвэрийн утаа, тортог орчны хөрс болон агаарыг тодорхой хэмжээнд бохирдуулж, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, оршин сууж буй айл өрхүүдэд хүндрэл үүссэн талаар олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдэж эхэлсэн.

2.11. Үүнээс шалтгаалан Засгийн газраас Таван толгой түлш ХХК-ийн баруун бүсийн үйлдвэрийг нүүлгэх шийдвэр гаргасны дагуу тус үйлдвэрийг нүүлгэн шилжүүлэх нь ихээхэн хэмжээний зардал шаардагдаж, анх үйлдвэрийг байгуулахад хийсэн зарим хөрөнгө оруулалт үр дүнгүй болох эрсдэлтэй тул эхний ээлжид тус үйлдвэрийн тоосжилт, тортгийг үүсгэж байгаа эх үүсвэрийг арилгах талаар судалгаа хийж, нүүлгэн шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх шаардлагатай байна.

2.12. Сайжруулсан шахмал түлшний үндсэн түүхий эд болох эрчим хүчний нүүрс нийлүүлэх гэрээг Энержи Ресурс ХХК-тай 2018 онд 5 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд тус гэрээ 2023 онд дуусгавар болох тул цаашид гэрээ сунгахгүй бол шаардлага хангасан түүхий эдийн дутагдалд орж, үйлдвэрлэл тасалдах эрсдэлтэй байна.

2.13. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн түүхий нүүрсний үзүүлэлтэд байгаа хүхэрлэг хий, азотын давхар исэл, тоосжилтын хэмжээг одоо байгаа үзүүлэлтүүдээс бууруулах боломж байгаа тул Таван толгой түлш ХХК нь нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийг бий болгох судалгааны ажлыг эхлүүлжээ.

2.14. Зөвлөх үйлчилгээний ажлын тайланд дурдсанаар сайжруулсан шахмал түлш хэрэглэж эхэлсэн (2019 оны 10 дугаар сараас 2020 оны 3 дугаар сарыг хүртэл) хугацааг түүхий нүүрс хэрэглэж байсан (2018 оны 10 дугаар сараас 2019 оны 3 дугаар сарыг хүртэл) мөн үетэй харьцуулбал агаар дахь PM2.5, PM10 тоосонцорын хэмжээ 37.7 хувиар тус тус буурсан ч хийн бохирдуулагч болох хүхрийн давхар исэл (SO₂) 98 хувиар, азотын давхар исэл (NO₂) 53.8 хувиар тус тус нэмэгдсэн байна.

2.15. Сайжруулсан шахмал түлшний хор аюулын хамгийн эрсдэлтэй, нийгмийн эрүүл мэндэд учруулж буй тулгамдсан асуудал нь угаарын хийн хурц болон архаг хордлого, түүнээс шалтгаалсан нас баралтын асуудал болохыг олон улс оронд эрдэмтэд судлан тогтоожээ.

2.16. Сайжруулсан шахмал түлшийг 2019 оны 10 дугаар сараас эхлэн хэрэглэж эхэлснээс угаарын хийн хордлогод өртсөн хүн амын тоо нэмэгдсэн тул Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/750 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1245 дугаар захирамжийг тус тус үндэслэн 3,512.0 сая төгрөгийн 200.0 мянган ширхэг угаарын хий мэдрэгчийг БНХАУ-ын “PGST” компанитай шууд гэрээ байгуулан худалдан авч, нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд үнэ төлбөргүйгээр тараасан байна.

2.17. Сайжруулсан түлш хэрэглэж эхэлсэн (2019 оны 10 дугаар сараас 2020 оны 3 дугаар сарыг хүртэл) хугацааг түүхий нүүрс хэрэглэж байсан (2018 оны 10 дугаар сараас 2019 оны 3 дугаар сарыг хүртэл) хугацаанд бүртгэгдсэн өвчлөлийн тохиолдлыг харьцуулан судлахад уушгины архаг бөглөрөлт өвчин, даралт ихсэх болон зүрхний шигдээс өвчний хувьд өөрчлөлт ажиглагдаагүй болно.

Нийслэлийн хэмжээнд сайжруулсан түлшний борлуулалтын цэгийг тооцоо, судалгаагүй нэмснээс борлуулалтын урамшууллыг хянаж, баталгаажуулахад хүндрэл үүссэн байна

2.18. Таван толгой түлш ХХК-ийн Борлуулалт, маркетингийн хэлтсийн 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 5 дугаар хурлын тэмдэглэлээр гэр хорооллын 400 өрхийн дунд 1 борлуулалтын цэг бий болгох талаар гишүүдээс гаргасан саналыг дэмжиж, 356 борлуулалтын цэг байгуулж, борлуулагч нартай гэрээ байгуулсан бөгөөд оны эцэст 26 цэг нэмж, нийт 382 цэгтэй болсон байна.

2.19. Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор нийслэлийн алслагдсан 3 дүүрэг, төвийн 6 дүүргийн 5 хороог агаарын чанарын бүсэд шинээр нэмж, өөрчлөлт оруулснаас сайжруулсан түлшний борлуулалтын цэгийн тоог нэмэх шаардлагын дагуу тооцоо судалгаагүйгээр Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1273 дугаар захирамжаар 51, Таван толгой түлш ХХК-ийн Гүйцэтгэх захирлын дараах тушаалаар 628 цэг нэмж, нийт 679 цэгтэй болсон байна.

- 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/132 дугаар тушаалаар 313,
- 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/138 дугаар тушаалаар 76,
- 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/144 дүгээр тушаалаар 99,
- 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/151 дүгээр тушаалаар 140.

2.20. Борлуулалтын урамшуулалд 2019 онд 1,897.7 сая төгрөг, 2020 онд 5,763.4 сая төгрөгийг борлуулагч нарт олгосон бөгөөд Тавантолгой түлш ХХК-тай гэрээ байгуулсан борлуулагч нарт олгосон урамшууллын ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг аль байгууллага хариуцан төлөх нь тодорхойгүй, батлагдсан төсөв байхгүйгээс шалтгаалан төлөөгүйгээс нийт 1,034.2 сая төгрөгийг өр төлбөр үүссэнийг шийдвэрлээгүй байна.


2.21. Таван толгой түлш ХХК-аас ирүүлсэн анхан шатны баримт, тооцоо нийлсэн актыг Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар хянаж, борлуулагч нарт олгох борлуулалтын урамшууллыг санхүүжүүлсэн боловч тус газар нийслэлийн хэмжээнд сайжруулсан шахмал түлш борлуулж байгаа 679 цэгийн борлуулалтын хэмжээг бүрэн хянаж, тооцоог бодож, баталгаажуулж чадахгүй байна.

Гэр хорооллын айл өрхөд үзүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн 7,319.4 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг ямар байгууллага хариуцан төлөх нь тодорхой бус байна

2.22. Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6¹⁰ дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг баталж, журмын 2,1¹¹, 2,2¹²-ын заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооноос дараах тогтоолыг гаргасан байна. Үүнд:

- “Нийслэлийн гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээ, халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувиар бууруулж хөнгөлөлт үзүүлэх тухай” 2017 оны 203, 2018 оны 317, 2019 оны 433,
- “Төв, Зүүн, Өмнөд, Баруун, Алтай-Улиастай эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх тухай” 2017 оны 204, 2018 оны 318, 2019 оны 434, Засгийн газрын 2020 оны 115 дугаар тогтоолоор дээрх журмын 2.2 дахь заалтын “50 хувиар” гэснийг “100 хувиар” болгон өөрчилсөн.

2.23. Гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээ, халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифын хөнгөлөлтөд 2017-2020 онд нийт 47,673.4 сая төгрөг олгохоос Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо 40,354.0 сая төгрөгийг санхүүжүүлж, 7,319.4 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр үүссэн байна.



2.24. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны жилийн эцсийн санхүүгийн тайланд 2017-2020 онд хуримтлагдсан 7,319.4 сая төгрөгийн өр төлбөрийг тайлагнаагүй байна.

2.25. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд олгох шөнийн тарифын хөнгөлөлтөд 2017-2020 онд нийт 35,465.5 сая төгрөгийн хөнгөлөлт олгохоос, гүйцэтгэлээр 47,673.4 сая төгрөгийг олгохоор тооцоолж, 12,207.9 сая төгрөгөөр илүү тооцоолсон байна.

¹⁰ энэ хуулийн 14.1¹⁰-д заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан, агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд үзүүлэх цахилгаан эрчим хүчний үнийн урамшууллын хэлбэр, хувь хэмжээг тогтоох, урамшууллыг улсын төсвөөс санхүүжүүлэх
¹¹ Агаарын тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан болон нийслэлийн гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээ, халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувиар бууруулж хөнгөлөлт үзүүлнэ.
¹² Аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээ болон халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувиар бууруулж хөнгөлөлт үзүүлнэ.

2.26. Эрчим хүчний яамнаас томилогдсон Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн 2017-2020 оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсэг"-ийн дүгнэлтээс үзэхэд судалгааны түүвэрт хамрагдсан нийслэлийн гэр хорооллын айл өрхийн 31.5 мянга буюу 23 хувь нь цахилгаанаар халаалтаа шийдсэн, 105.6 мянга буюу 77 хувь нь цахилгаан халаагуургүй байна.

2.27. Нийт хөнгөлөлтөд хамрагдсан цахилгааны хэрэглээний 55 хувийг нь цахилгаан халаагууртай буюу тарифын хөнгөлөлтөд хамрагдах шаардлагатай айл өрхийн цахилгааны хэрэглээ, 45 хувийг нь цахилгаан халаагуургүй буюу цахилгааны тарифын хөнгөлөлтөд хамрагдах шаардлагагүй айл өрхийн цахилгааны хэрэглээ эзэлж байна.

2.28. Судалгааны явцад Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн хэрэглэгчдэд үйлчлэх 9 төвийн хэмжээнд хамгийн өндөр хэрэглээтэй айл өрхийн жагсаалтыг гаргаж, газар дээр нь шалгахад 3-5 давхар амины орон сууц, хотхоны хэрэглээ гарсан бөгөөд эдгээр хэрэглэгчид сард дунджаар **81,560.4 кВт.ц** хэрэглэсэн байна. Тухайлбал:

- Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь 2015 онд Хан-Уул дүүргийн Жаргалантын аманд дунджаар 105 м2 талбайтай, 2 давхар орон сууц бүхий 100 айлын ажиллагсдын орон сууц барьсан бөгөөд халаалт, хэрэгцээний халуун усны халаалтыг цахилгаан бойлороор шийдсэн байна. Энэхүү Жаргалант Эко хотхоноос байнгын оршин суудаг 89 айлын цахилгааны хэрэглээг шүүж үзэхэд хамгийн өндөр хэрэглээтэй 107289 кодтой айл хүйтний улирлын 1 сард л гэхэд 3600 кВт.ц цахилгаан хэрэглэж, цахилгааны төлбөрт 622.0 мянган төгрөг төлж, үүнээс 200.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг авчээ.

2.29. Өндөр хэрэглээтэй айл өрхүүд нь ихэвчлэн Дархан цаазат Богд хан уулын аманд баригдсан амины орон сууц, орон сууцны хотхон, Ар гүнт, Гачуурт, Шарын ам, Баянголын амны зуслангийн хэрэглэгчид бөгөөд хэт өндөр хэрэглээтэй нийт 2715 хэрэглэгчид нь хөнгөлөлтөд хамруулсан цэгийн 2 хувь байгаа хэдий ч цахилгааны хэрэглээний 19.6 хувийг эзэлж байна.

2.30. Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгын дүнгээс харахад “Та цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтөд хамрагдсанаар гэр, байшингийн дулааны асуудлаа цахилгааны эх үүсвэрээр шийдэж чадсан уу” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 69.2 хувь нь шийдэж чадаагүй гэж хариулсан бол, яагаад дулааны асуудлаа цахилгааны эх үүсвэрээр шийдэж чадаагүй шалтгааныг тодруулахад 41.8 хувь нь шаардлагагүй, 22.7 хувь нь цахилгааны хүчдэл хүрэлцдэггүй гэж хариулжээ.

2.31. Ажлын хэсгийн дүгнэлт болон санал асуулгын дүнгээс үзэхэд агаарын чанарын бүсэд хамаарах гэр хорооллын зорилтот айл өрхүүд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийг эдлээгүй байх магадлал өндөр байна.

2.32. Иймд Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1¹³, 15.3¹⁴ дахь хэсгийн дагуу агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах нийслэлийн зорилтот гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай байна.

2.33. Жилээс жилд гэр хорооллын айл өрхөд олгох шөнийн тарифын хөнгөлөлтөд хамрагдах айл, өрхийн тоо өссөнөөс Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо бүх аймаг, нийслэлийн айл өрхөд олгох шөнийн тарифын хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг хариуцан хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байна.

¹³ Төрийн захиргааны төв байгууллага нь нутгийн захиргааны байгууллагатай хамтран агаарын бохирдлыг бууруулах зорилгоор агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, тухайн бүсэд мөрдөх журмыг батална.

¹⁴ Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг жил бүр шинэчлэн тогтооно.

Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төрийн нууцад хамаарахгүй зарим арга хэмжээг шууд гэрээгээр худалдан авсан нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна

2.34. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн зарцуулалтыг түүвэрлэн шалгалаа.

2.35. Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд Тагнуулын Ерөнхий газрын зөвшөөрлөөр зарим худалдан авалтыг төрийн нууцад хамааралтай гэж үзэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасны дагуу шууд гэрээ байгуулсан нь батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна. (Зөрчлийн дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү)

2.36. Мөн гэрээний дагуу барааг бүрэн хүлээн аваагүй, тоо мэдээ зөрүүтэй, чанарын шаардлага хангаагүй бараа нийлүүлсэн, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг дараах зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлээ. Тухайлбал:

- БОАЖС-ын 2019 оны А/283, А/323, А/435 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Улаанбаатар хотын усан халаалтын бага, дунд оврын халаалтын зуухны утааны хий дэх үнс, тоосонцрыг барих төхөөрөмж худалдан авах, суурилуулах ажил”-ын хүрээнд нийт 290 ширхэг шүүлтүүрийг 12,029.7 сая төгрөгөөр худалдан авч, суурилуулан ашиглалтад бүрэн оруулах ажлыг гүйцэтгүүлэхээр БНХАУ-ын Jiangshu Fengyu environmental protection, Center New Power, Hebei Yonghua environment Protection зэрэг компанитай шууд гэрээ байгуулж, нийт 10,390.6 сая төгрөгийн 290 ширхэг шүүлтүүрийг хүлээн авсан гэх боловч хүлээн авах комиссыг албан ёсоор томилж, хүлээн авч, акт үйлдээгүй, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зуухны ашиглалтын талаарх мэдээлэл хангалтгүй, эд хариуцагч, ажил хариуцсан мэргэжилтнүүдийн шүүлтүүрийн тоо мэдээлэл зөрүүтэй, одоог хүртэл аж ахуйн нэгж байгууллагад суурилуулсан шүүлтүүрийн тоонууд эцэслэн шийдвэрлэгдээгүй;
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхөд сайжруулсан түлш нийлүүлэх, сайжруулсан түлш үйлдвэрлэх үйлдвэрүүдийн хүчин чадал, үйл ажиллагааны түвшнийг тогтоож, дүгнэлт гаргах ажлын хэсгийн 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дүгнэлт, БОАЖС-ын 2018 оны А/425 дугаар тушаалыг тус тус үндэслэн 5 компанитай нийт 3,400.0 сая төгрөгийн 68000 тонн сайжруулсан түлш нийлүүлэх гэрээг шууд байгуулж, гэрээний дагуу 30 хувийн урьдчилгаанд 1,100.0 сая төгрөгийг олгожээ. Гэрээний хэрэгжилтийг 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр дүгнэхэд Усу Коал ХХК гэрээний дагуу 9000 тонн сайжруулсан түлш нийлүүлэхээс 8615 тонныг дутуу нийлүүлсэн буюу 241.7 сая төгрөгийн төлбөрийг буцаан төвлөрүүлээгүй.
- Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2,900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2000 ширхэг гэр хорооллын сайжруулсан ариун цэврийн байгууламж барьж гүйцэтгэх тендер зарлан Хэмжилзүй ХХК-тай 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдөр 1,406.5 сая төгрөгийн, Дархан нэгдэл ХХК-тай 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 1,445.4 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулж, Хэмжил зүй ХХК-тай байгуулсан ажлын гэрээнд 28.1 сая төгрөг, Дархан нэгдэл ХХК-тай байгуулсан ажлын гэрээнд 28.9 сая төгрөг, нийт 57.0 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлэхээр тусгасан боловч улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй тус 2 арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

2.37. Аудитын явцад дээр дурдсан БНХАУ-ын нэр бүхий 3 компанитай байгуулсан шууд гэрээгээр нийт 10,390.6 сая төгрөгийн 290 ширхэг шүүлтүүртэй холбоотой зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжилтийг ирүүлээгүй, Монгол Улсад хэдэн ширхэг шүүлтүүр хилээр орж ирсэн талаарх мэдээллийг Гаалийн ерөнхий газраас авахад Jiangshu Fengyu environmental protection ХХК-ийн оруулж ирсэн 50 ширхэг шүүлтүүр бүртгэгдэж, үлдсэн 240 ширхэг шүүлтүүрийн мэдээлэл бүртгэгдээгүй байна. Мөн Улаанбаатар хотын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагад суурилуулсан шүүлтүүрийг ашиглаж буй мэдээллийг ирүүлээгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

2.38. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны тогтоолоор баталсан 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, тооцоо судалгаагүй, хаана, хэзээ ашиглах нь тодорхойгүй арга хэмжээг санхүүжүүлж, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7¹⁵ дахь хэсгийг зөрчсөн байна. Үүнд:

- Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захиралтай 292.0 сая төгрөгийн 28 нэр төрлийн хийн шинжилгээний багажуудыг нийлүүлэх 2019 оны 2019/158 дугаар гэрээг шууд байгуулан санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн боловч гэрээнд бараа нийлүүлэх хугацааг тодорхой тусгаагүй, барааг нийлүүлээгүй;
- БОАЖС-ын 2019 оны А/790 дугаар тушаалыг үндэслэн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэнтэй “2019 оны 12 сараас эхлэн 2020 оны 5 сар хүртэл Тавантолгой тули ХХК-ийн 504 борлуулалтын цэгээс түүвэрлэн сайжруулсан түлшний дээж авч чанарын хяналт, шинжилгээ, судалгаа орчны бохирдлын хяналт хийх” 138.0 сая төгрөгийн судалгааны ажлыг гэрээг байгуулж, санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн боловч судалгааны ажлыг дуусгах хугацааг гэрээнд тусгаагүй, тус ажлын зориулалт тодорхой бус, гэрээний дагуу хийсэн ажил байхгүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй байна;
- БОАЖС-ын 2019 оны А/781 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1357 дугаар захирамжаар Нийслэлийн 6 дүүргийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 95 хорооны орон тооны бус ажилтныг урамшуулах, байгальд ээлтэй дэвшилтэт технологи ашиглан халаалт, гэр байшингаа дулаалсан шилдэг өрхийн шагнал, урамшуулалд гэр байшингаа дулаалсан шилдэг айл өрхөд /95*200.0 мянган төгрөг/ 19.0 сая төгрөг, Манжуур хотын аялалд /380*280.0 мянган төгрөг/ 106.4 сая төгрөг нийт 125.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гэр байшингаа дулаалсан өрхөд олгох урамшууллын 19.0 сая төгрөгийг Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт эрх шилжүүлж шилжүүлж, Манжуур хотын аялал цар тахал гарч хил хаагдсантай холбоотой аялал жуулчлалын үйл ажиллагаа зогссон тул 2019, 2020 онуудад Нийслэлийн төрийн санд 106.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн;
- “Баруун Монголын Экологи Төв” ТББ-д агаарын бохирдлыг бууруулах нэгдсэн судалгааны эмхэтгэл бэлтгэх ажлын 80 хувийн урьдчилгаа 36.0 сая төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 25-нд шилжүүлсэн боловч тус ажлыг дуусгаж хүлээн аваагүй, ямар ажил хийсэн нь тодорхойгүй байна;
- УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.3.4¹⁶, Засгийн газрын 2019 оны 23 дугаар хуралдаанд БОАЖС-ын Туул голын бохирдлыг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний талаар Засгийн газрын гишүүдэд хүргэсэн мэдээллийг үндэслэн хуралдааны тэмдэглэлээр тус төслийг хэрэгжүүлэхийг үүрэг болгосныг үндэслэн тус сайдын 2019 оны А/360 дугаар тушаалаар “Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах дэвшилтэт техник, технологи инновацыг дэмжих, урамшуулах” ажлын хүрээнд хэрэгжүүлэх Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төслийн 800.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулах эрхийг Туул голын сав газрын захиргаанд шилжүүлсэн буюу 70 хувийн урьдчилгаанд 548.8 сая төгрөгийг олгосон боловч ажлын даалгаварт тусгасан ажлыг бүрэн хийгээгүйгээс үлдэгдэл 231.2 сая төгрөгийг олгоогүй, ажлыг гүйцэтгэх явцад 2019 оны 11 дүгээр сарын 7-нд төсвийг 1,440.5 сая төгрөг байхаар магадлалын дүгнэлт гарч, төсөвт өртөг нэмэгдсэнээс дахин санхүүжилт хийх боломжгүй болсон байна.

2.39. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо дээр дурдсан арга хэмжээний хүрээнд хийсэн ажлыг хүлээн авах комисс томилон гэрээний хэрэгжилт үр дүнг тооцож, зөрчлийг арилгах арга хэмжээг авч, цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.40. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, зураг төслийг гэрээнд заасан хугацаанд хийгээгүй, санхүүжилт олгоогүй зэрэг шалтгаанаар дараах арга хэмжээ он дамжин хэрэгжиж байна. Үүнд:

¹⁵ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгаагаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

¹⁶ Томоохон хот, суурин газарт агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.

- *БОАЖС-ын 2020 оны А/333 дугаар тушаалаар “Гэр хорооллын ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн лаг хаягдлыг байгальд халгүй аргаар шатааж устгах туршилтын төсөл хэрэгжүүлэх” төсөл, арга хэмжээний хүрээнд 1,100.0 сая төгрөгийн барилгын ажил гүйцэтгэх ажлыг зохион байгуулах эрхийг Чингэлтэй дүүргийн ЗДТГ-т шилжүүлж, тус ажлыг түлхүүр гардуулах нөхцөлөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Мөнгөн болдог” ХХК шалгаруулан 1,012.4 сая төгрөгөөр барилгын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Тус барилгын зураг төсвийг 2020 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 01-ний өдөр дуусгах, барилга угсралтын ажлыг 10 дугаар сарын 01-ний өдөр эхлэн 12 дугаар сарын 31-ний өдөр ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээнд тусгасан боловч зураг төсвийг гэрээнд заасан хугацаанд хийгээгүйгээс тайлант онд санхүүжилт хийгээгүй;*
- *БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/226 дугаар тушаалаар “Аюултай хог хаягдлын хадгалах, агуулах жишиг зураг, төсөв боловсруулж батлуулах, стандартын шаардлага хангасан аюултай хог хаягдлын агуулахыг 21 аймагт байгуулах” ажлын үнэлгээний хороог байгуулсан бөгөөд зураг төсвийг хийлгэж магадлагаар баталгаажуулахтай холбоотой хугацаа алдаж, 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/399 тушаалаар үнэлгээний хороонд өөрчлөлт оруулан худалдан авах ажиллагааг зарласан. Худалдан авах ажиллагаанд 4 компани оролцон Мөнх-Өргөө ХХК, Цонбон тоосго ХХК хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах мэдэгдлийг 2020 оны 10 дугаар сарын 28-нд хүргүүлсэн боловч гэрээг 2020 оны 11 дүгээр сарын 30-нд байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2¹⁷ дахь хэсгийг зөрчсөн, тус барилгыг 2020 оны 11 дүгээр сарын 27-нд эхэлж, 2020 оны 12 дугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулахаар гэрээнд тусгасан нь гэрээнд хэрэгжих хугацааг бодитой тооцоогүй, мөн аюултай хог хаягдлын түр хадгалах агуулахыг 21 аймагт 1,874.3 сая төгрөгөөр барихаар төлөвлөн барилгын зураг, төсөв тооцоо судалгааг хийх явцад 6 аймагт хэрэгжүүлэхээр болсон зэрэг нь тооцоо судалгааг үндэслэлтэй хийгээгүйтэй холбоотой байна.*

2.41. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/371, 2019 оны А/246 дугаар тушаалыг үндэслэн дараах 8 аймагт агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж, нийт 3,800.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- *Дархан-Уул 450.0 сая төгрөг,*
- *Орхон 450.0 сая төгрөг,*
- *Өвөрхангай 510.0 сая төгрөг,*
- *Ховд 1,400.0 сая төгрөг,*
- *Увс 400.0 сая төгрөг,*
- *Архангай 300.0 сая төгрөг,*
- *Баянхонгор 250.0 сая төгрөг,*
- *Хэнтий 40.0 сая төгрөг.*

2.42. Аудитын явцад дээрх 8 аймагт олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг тухайн аймаг дахь Төрийн аудитын газраар хянуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- *Дархан-Уул аймаг 246 ширхэг зуухны төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч зориулалтыг өөрчлөн 335.4 сая төгрөгийн 3190 ширхэг цахилгаан халаагуурыг гэр хорооллын айл өрхүүдэд тараасан.*
- *Ховд аймгийн Засаг даргад тус арга хэмжээний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө байхгүй байхад 800.0 сая төгрөг шилжүүлсэн, тус санхүүжилтээс 36 айлын хашааны хаалгыг сайжруулж, жигдрүүлэх, барилгын зураг төсөл боловсруулах зэрэг зориулалтын бус зардалд 116.0 сая төгрөгийг зарцуулсан.*
- *Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 6 багийн гэр хорооллын айл өрхөд 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийт 100.0 сая төгрөгийн 200 ширхэг зуух нийлүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр Блейз Тех ХХК-тай шууд гэрээг байгуулсан боловч гэрээнд заасан хугацаанд зуухыг нийлүүлээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.*

2.43. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэх нэгдсэн цогц бодлого байхгүй, суурь судалгаагүй, шалгуур үзүүлэлт тодорхой бус, хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг нарийвчлан төлөвлөөгүй байхад аймгуудад санхүүгийн

¹⁷ Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.

дэмжлэг олгож, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлж, дүгнээгүй байгаа нь төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.

2.44. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/138 дугаар тушаалыг үндэслэн холбогдох байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр Хөвсгөл, Увс, Ховд, Орхон аймгийн Дулааны станцын халаалтын зууханд шүүлтүүр суурилуулах нийт 3,000.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхээр БНХАУ-ын Hebei Yonghua environmental Protection equipment компанийн Монгол Улс дахь төлөөлөгч “Кан Мэй Хуан Бао” ХХК-тай шууд гэрээ байгуулж, 1,800.0 сая төгрөгийн урьдчилгааг олгосон боловч гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгээгүй, ажлыг хүлээн авах комиссыг томилоогүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, зориулалтыг өөрчилсөн зэрэг дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Увс аймгийн Дулааны 2 дугаар станц ТӨХК-ийн халаалтын зууханд 2 ширхэг шүүлтүүр суурилуулсныг ашиглагч тал хүлээн авч хэвийн ашиглаж байгаа боловч Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо тус ажлыг хүлээн авах комисс томилоогүй.
- Ховд аймгийн Дулааны станц ТӨХК-ийн халаалтын зууханд 2 ширхэг шүүлтүүр суурилуулсан боловч нэг зууханд суурилуулсан шүүлтүүр 2020 оны 11 дүгээр сарын 5-ны өдрөөс хойш ажиллаагүй, тус ажлыг хүлээн авах комисс томилогдоогүй, гэрээний дагуу баталгаат хугацаанд буюу 3 жил гүйцэтгэгч компани засвар үйлчилгээг хариуцах үүрэгтэй боловч Ковид 19 цар тахал гарсан тул засвар үйлчилгээ хийгээгүй.
- Хөвсгөл аймгийн Дулааны станц ТӨХК-ийн халаалтын зууханд 2 шүүлтүүр суурилуулж, хэвийн ажиллаж байсан боловч 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хийсэн байгууллагын дотоод хяналтаар 10 орчим шүүлтүүрийн уут цоорсон зөрчлийг илрүүлэн шүүлтүүрийн үйл ажиллагааг зогсоож, засвар үйлчилгээг хийлгэх талаар Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо болон гүйцэтгэгч байгууллагад албан бичгээр хандсан байна.
- Орхон аймгийн сургууль, цэцэрлэгийн халаалтын зууханд нийт 8 шүүлтүүр суурилуулахаас 22 дугаар цэцэрлэг 2021 онд уурын зуухандаа өргөтгөл хийх болсноос шалтгаалан 2 шүүлтүүрийг суурилуулаагүй, гэрээний дагуу 17, 20 дугаар сургуулийн халаалтын зууханд суурилуулсан шүүлтүүрийг 2020 оны 9 дүгээр сарын 17-ноос 18-ны өдөр туршилтаар ажиллуулсан боловч бөглөрч ажиллахгүй болсон, 17-р сургуулийн цахилгааны хүчин чадал хүрэхгүйгээс тус сургууль цахилгаангүй болж, үнс цацагдсан тул ажиллуулаагүй байна.
- Орхон аймгийн Дулааны станцын халаалтын зууханд шүүлтүүрийг суурилуулаагүй тул үлдэгдэл санхүүжилтийг хэрхэн тооцож олгох асуудлыг шийдээгүй байна.

2.45. Дулааны станцын халаалтын зууханд тавьж байгаа өндөр үнэтэй шүүлтүүрийг Монгол Улсад оруулж ирэхээс өмнө шүүлтүүрийг ашиглах гарын авлагыг монгол хэлэнд хөрвүүлээгүй, эвдрэл гэмтлийг засах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгээгүй, шүүлтүүрийн уутыг дотооддоо үйлдвэрлэх боломжтой эсэхийг судлаагүй, техник хяналтыг ямар байгууллага тавих нь тодорхойгүй, харьцуулсан үнийн судалгаа хийхгүйгээр шууд оруулж ирснээс шалтгаалан тухайн шүүлтүүрийг суурилуулсан болон хүлээн авсан байгууллагад засварын зардал их гарах хүндрэл үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ.

2.46. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны төсөв, үйл ажиллагаа болон агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой зардлын санхүүжилтийг 2017-2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн “Агаарын бохирдлыг бууруулах уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлж байгаа бөгөөд төсвийн зардлыг ангилал бүрээр төлөвлөж баталдаггүйгээс зардлын хэмнэлт, хэтрэлтийг тооцох, зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг хянах боломжгүй болгож байна.

2.47. Ажлын албаны төсвийн бие даасан байдлыг хангаагүйгээс батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зардлыг ангилал хооронд шилжүүлэхийг хориглосон Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай зөрчилдөж байна.

2.48. Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний баталсан зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй, худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчин шууд гэрээ байгуулсан зэрэг дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- “Цэвэр агаартай хот аяныг зохион байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1332 дугаар захирамжийг үндэслэн агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны хөтөлбөрийн батлагдсан зардлын 210.0 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг нийслэлийн Соёл, урлагийн газарт “Мөсөн хотхон байгуулах” зардлыг санхүүжүүлэхээр шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁸, 16 дугаар зүйлийн 16.5.5¹⁹ дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.7²⁰ дахь хэсгийг зөрчсөн тул аудитын явцад зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2021 оны 01/20 дугаар албан бичгээр хүлээн авлаа.
- Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/864 дугаар захирамжаар “Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийслэлийн гэр хорооллын айл өрхийн сайжруулсан түлшийг нөөцлөхөд шаардлагатай агуулах түрээслэх” ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гэрээ байгуулахыг ажил хариуцсан дарга нарт үүрэг болгосон боловч Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 6 дугаар хурлын тэмдэглэлээр стандартын шаардлага хангасан агуулахын судалгааг гарган 2020 оны 7 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний хооронд 35 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай шууд гэрээ байгуулж, нийт 47247.17 м2 талбайг түрээслэн 1,391.8 сая төгрөг төлсөн байна.

2.49. Нийслэлийн хэмжээнд “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 17/10 дугаар тогтоолоор “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байгаа боловч 2017-2020 онд батлагдаагүй “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-т нийт 9,668.6 сая төгрөгийг нийслэлийн төсвөөс зарцуулсан нь төсвийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 12. “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрт 2017-2020 онд нийслэлийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн судалгаа (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2020 он	НИЙТ
Арга хэмжээний тоо	13	7	7	1	28
Төсөвт өртөг	2,245.9	3,278.8	4,450.0	950.0	10,924.7
Гэрээний дүн	2,093.4	3,108.8	4,420.9	899.3	10,522.4
Олгосон санхүүжилт	1,816.9	2,654.8	4,342.6	854.4	9,668.7

Эх үүсвэр: Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын тайлан, мэдээ

Агаар, орчны бохирдолтой холбоотой зарим төлбөр, хураамжийг ногдуулах журам, жишиг хэмжээг тооцох аргачлал байхгүйгээс хуульд заасан орлогууд бүрэн төвлөрдөггүй байна

2.50. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1²¹, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1²², Хог хаягдлын тухай

¹⁸ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹⁹ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

²⁰ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

²¹ Дор дурдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага агаарын бохирдлын төлбөр төлөгч байна

4.1.1. түүхий нүүрс олборлогч;

4.1.2. органик уусгагчийг үйлдвэрлэгч;

4.1.3. органик уусгагчийг импортлогч;

4.1.4. автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч;

4.1.5. агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл эзэмшигч;

4.1.6. агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.

²² Ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсны төлбөр төлөгч байна.

хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1²³ дэх хэсгийг тус тус үндэслэн холбогдох хууль, журамд заасан хувь, хэмжээгээр тооцон улс, орон нутгийн төсөвт 2016-2020 онд дараах орлогыг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 13. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын судалгаа (сая төгрөгөөр)

Үзүүлэлт		Агаарын бохирдлын төлбөр	Ус бохирдуулсны төлбөр	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	Нийт дүн
2016 он	төлөвлөгөө	17,092.6	14.2	15,768.8	32,875.6
	гүйцэтгэл	23,050.5	27.2	15,412.6	38,490.3
2017 он	төлөвлөгөө	37,794.3	21.0	18,036.6	55,851.8
	гүйцэтгэл	40,735.9	548.3	17,526.5	58,810.7
2018 он	төлөвлөгөө	34,377.7	19.5	18,534.0	52,931.2
	гүйцэтгэл	48,661.8	317.1	18,452.1	67,430.9
2019 он	төлөвлөгөө	50,787.7	306.8	19,949.4	71,043.9
	гүйцэтгэл	58,456.3	331.3	18,055.5	76,843.1
2020 он	төлөвлөгөө	41,899.5	379.0	18,815.4	61,093.9
	гүйцэтгэл	34,109.5	412.0	18,470.8	52,992.3

Эх сурвалж: Сангийн яам, Татварын ерөнхий газраас авсан судалгаа

2.51. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, холбогдох журмын дагуу тооцож, 2016-2020 онд улсын төсөвт нийт 179,270.8 сая төгрөг, орон нутгийн төсөвт 25,743.2 сая төгрөг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу 2017-2020 онд улсын төсөвт нийт 48.4 сая төгрөг, орон нутгийн төсөвт 1,636.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2.52. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд 2019 оны 5 дугаар сард нэмэлт, өөрчлөлт оруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2019 оны А/816/218 дугаар хамтарсан тушаалаар “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ”-г тус тус баталснаар ус бохирдуулсны төлбөрийг бүрэн ногдуулах, хураах эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд 2020 оноос өмнө тус төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөдөггүй байсан байна.

2.53. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүүгийн асуудалд эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална” гэж заасан боловч тус журам, аргачлал батлагдаагүй байна.

²³ Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө.

2.54. Татварын ерөнхий газар дээрх журмын төсөлд Усны газрын мэргэжилтнээр дамжуулан ус бохирдуулсны төлбөрийг ногдуулах, хураах ажиллагааг хялбаршуулах чиглэлээр санал хүргүүлсэн байна.

2.55. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан түүхий нүүрс олборлогчдоос 2016-2020 онд 176,809.6 сая төгрөг, органик уусгагч үйлдвэрлэгч, импортлогчдоос 69.6 сая төгрөг, автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигчдээс 10,061.4 сая төгрөг, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл эзэмшигчдээс 357.8 сая төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлжээ.

Дүрслэл 4. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын судалгаа (сая төгрөгөөр)



Эх сурвалж: СЯ, ТЕГ-ын мэдээлэл

Хүснэгт 14. Агаарын бохирдлын төлбөрийн 2016-2020 оны судалгаа (сая төгрөгөөр)

Агаарын бохирдлын төлбөр төлөгч		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт дүн
Түүхий нүүрс олборлогч	ТТ тоо	33	42	49	44	35	203
	Төлөвлөгөө	13,026.8	32,076.3	25,000.0	42,002.3	37,500.0	149,605.4
	гүйцэтгэл	17,481.2	34,676.7	41,653.8	46,234.7	36,763.2	176,809.6
Органик уусгагч үйлдвэрлэгч, импортлогч	ТТ тоо	18	16	17	11	10	72
	Төлөвлөгөө	30.0	2.5	60.0	60.0	100.0	252.5
	гүйцэтгэл	9.8	13.3	12.5	17.6	16.4	69.6
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч	ТТ тоо	241864	256230	272482	284112	286157	1340845
	Төлөвлөгөө	1,594.7	1,950.0	1,818.0	1,897.8	2,400.0	9,660.5
	гүйцэтгэл	1,978.2	1,958.8	2,186.3	1,772.0	2,166.1	10,061.4
Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл эзэмшигч	ТТ тоо					22	22
	Төлөвлөгөө	120.0	10.0		40.0		170.0
	гүйцэтгэл					357.8	357.8
НИЙТ ДҮН	ТТ тоо	241915	256288	272548	284167	286224	1341142
	Төлөвлөгөө	14,771.5	34,038.8	26,878.0	44,000.1	40,000.0	159,688.4
	гүйцэтгэл	19,469.2	36,648.8	43,852.6	48,024.3	39,303.5	187,298.4

Эх үүсвэр: ТЕГ-ын мэдээлэл

2.56. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т заасан Улаанбаатар хотод бүртгэлтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигчдээс хуулийн дагуу агаарын бохирдлын төлбөрийг бүрэн ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн эсэхийг Автотээврийн үндэсний төвийн нэгдсэн мэдээллийн сангаас авсан мэдээлэлд тулгуурлан судалгаа хийж үзэхэд 2016-2020 онд нийслэлд бүртгэлтэй нийт автотээврийн хэрэгсэл эзэмшигчдийн дунджаар 59.5 хувь нь агаарын бохирдлын төлбөр төлсөн байна.

2.57. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын /хуучин нэрээр/ 2011 оны А/63/67 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох журам”-д заасны дагуу агаарын бохирдлын төлбөрийн хэмжээг автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан 6 ангилж, жилд 1800-9500 төгрөгийн төлбөр ногдуулж байна.

Хүснэгт 15. Автотээврийн хэрэгслийн 2016-2020 онд төлсөн агаарын бохирдлын төлбөрийн судалгаа (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Улаанбаатар хотод бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн тоо	431620	469633	489260	428033	546130
Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 8.3-т заасны дагуу чөлөөлөгдөх автотээврийн хэрэгслийн тоо	25516	22203	22364	16447	11310
Агаарын бохирдлын төлбөр төлбөл зохих автотээврийн хэрэгслийн тоо	406104	447430	466896	411586	534820
Татвар төлсөн автотээврийн хэрэгслийн тоо	241864	256230	272482	284112	286157
Хамарсан хувь	59.6	57.3	58.4	69.0	53.5
Агаарын бохирдлын төлбөр төлөөгүй автотээврийн хэрэгслийн тоо	164240	191200	194414	127474	248663
Агаарын бохирдлын төлбөрийг нэмэгдүүлэх боломжит дүн (дундаж төлбөр буюу 3500 төгрөгөөр тооцов)	574.8	669.2	680.4	446.2	870.3

Эх сурвалж: ТЕГ, АТУТ-өөс авсан судалгаанд үндэслэсэн аудитын тооцоолол

2.58. Автотээврийн хэрэгсэл эзэмшигчдийн нэгдсэн бүртгэлийн тоо мэдээнд тулгуурлан бүртгэлтэй татвар төлөгчдөөс агаарын бохирдлын төлбөрийг бүрэн ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс 2016-2020 онд жилд дунджаар 648.2 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

2.59. Үндэсний аудитын газраас “Цэвэр агаарын сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн дараах зөрчлийг арилгах талаар арга хэмжээг аваагүй зөрчилтэй хэвээр байна.

- Автотээврийн техникийн хяналтын төвүүдэд ашиглаж байгаа автотээврийн хэрэгслээс агаарт ялгарах нүүрс хүчлийн хийг хэмжигч нь бохирдлыг хувиар тооцож байгаа нь Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т “авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс нэгж километр зайд явахад ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээг граммаар тооцож төлбөр тогтооно” гэж заасантай нийцэхгүй, агаарт хаях хорт утааны ялгаралтын хэмжээг бодитой тодорхойлж чадахгүй байна;
- Агаарын бохирдлын төлбөр төлөгчөөр гэр хорооллын айл өрхүүд болон хос тэжээлт²⁴ автомашины эзэмшигчдийг хамруулахгүй байх талаар эрх зүйн зохицуулалтгүй байгаа нь Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч”, 4.1.6-ийн “агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага агаарын бохирдлын төлбөр төлөгч байна” гэсэн заалттай зөрчилдөж, хэрэгжихгүйд хүргэж байна.

2.60. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Төлбөр төлөгч нь Агаарын тухай хуулийн 10.1²⁵-д заасан агаарын чанарын мэргэжлийн албаны дүгнэлтийг үндэслэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс тухайн жилд агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд төлнө” гэж заасныг үндэслэн 2016 онд 120.0 сая төгрөг, 2017 онд 10.0 сая төгрөг, 2019 онд 40.0 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч тус төлбөрийг төвлөрүүлээгүй байна.

2.61. Энэ нь Агаарын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газар агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодисын тоо хэмжээ, дүгнэлт гаргах чиг үүргийг хүлээсэн боловч 2016-2019 онд агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодисын тоо хэмжээг тооцох аргачлал байхгүй, агаарын бохирдлын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх нөхцөл бүрдээгүйгээс шалтгаалжээ.

²⁴ цахилгаан болон бензин хосолсон

²⁵ Агаарын чанарыг тодорхойлох, хяналт-шинжилгээ хийх, холбогдох мэдээ, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн алба /цаашид “мэргэжлийн алба” гэх/-ыг төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж ажиллуулна.

2.62. Агаарын бохирдлын томоохон эх үүсвэрээс агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодисын төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газрын 2011 оны 92 дугаар тогтоолоор агаар бохирдуулах 9 бодисыг 1-4 дүгээр зэрэглэлд ангилан төлбөрийн хувь хэмжээг баталсан боловч Цаг уур, орчны шинжилгээний газар томоохон суурин эх үүсвэрээс жилд агаарт гаргах бодисын хэмжээг зөвхөн 3 бодис буюу азотын исэл, хүхэрлэг хий, тоос гэсэн төрлөөр тодорхойлж, тэдгээрийн нийлбэр нь 100 тонноос их байгаа 24 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг Татварын ерөнхий газарт ирүүлснийг үндэслэн 2020 онд агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл эзэмшигчдээс 357.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2.63. Цаашид Цаг уур, орчны шинжилгээний газар Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд татварын алба болон татвар төлөгчдөд агаарын бохирдлын томоохон эх үүсвэрийн жилд ашигласан нүүрс, түүнээс ялгарсан үнсний хэмжээг Засгийн газрын 2011 оны 92 дугаар тогтоолоор баталсан агаар бохирдуулах 9 бодисыг 1-4 дүгээр зэрэглэлд ангилан тооцоолж өгөх шаардлагатай байна.

2.64. Агаарын болон ус бохирдуулсны төлбөрийг төвлөрүүлэх үйл ажиллагаанд оролцогч төрийн захиргааны төв болон бусад байгууллагууд холбогдох хуульд заасан журам, аргачлал боловсруулахдаа татварын албатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох ажлыг сайжруулж, улс, орон нутгийн төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах нь зүйтэй юм.

2.65. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т “энэ хуулийн 8.7.1²⁶-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох” гэж заасныг үндэслэн тухайн сум, дүүрэгт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхийн хүрээнд дараах аргачлалын дагуу тогтоож байна. Үүнд:

- *Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/368 дугаар тушаалаар баталсан “Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал”*
- *Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192/А/243 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”, “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”*

2.66. Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-т “Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө” гэж заасныг үндэслэн 2016-2020 онд 87,917.5 сая төгрөгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж, тус хуулийн 41.9-т заасны дагуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлыг санхүүжүүлсэн байна.

²⁶ хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангуулах

Дүрслэл 5. Хог хаягдлын үйлчилгээний хураамж (сая төгрөгөөр)

2020	ОН	гүйцэтгэл	18,470.8
		төлөвлөгөө	18,815.4
2019	ОН	гүйцэтгэл	18,055.5
		төлөвлөгөө	19,949.4
2018	ОН	гүйцэтгэл	18,452.1
		төлөвлөгөө	18,534.0
2017	ОН	гүйцэтгэл	17,526.5
		төлөвлөгөө	18,036.6
2016	ОН	гүйцэтгэл	15,412.6
		төлөвлөгөө	15,768.8

Эх үүсвэр: Сангийн яамны мэдээлэл

Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна

2.67. Үндэсний аудитын газраас 2018 онд “Цэвэр агаарын сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргад 5, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад 3, Сангийн сайдад 2 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид агаар, орчны бохирдол өсөж байгааг “царцаах болон бууруулах” нэгдсэн бодлогын хүрээнд эхний үе шатанд 8 арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх, хоёр дахь үе шатанд 8 арга хэмжээг хэрэгжүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэхийг зөвлөсөн байна.

2.68. Зөвлөмжийн хэрэгжилтийг Сангийн сайд, Нийслэлийн Засаг дарга нар 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлээгүй тул аудитын явцад албан бичиг хүргүүлж, хэрэгжилтийг тооцож үзэхэд 100 хувь хэрэгжсэн 2, 70 хувийн хэрэгжилттэй 8, 40 хувийн хэрэгжилттэй 9, огт хэрэгжээгүй 7 зөвлөмж байна.

Хүснэгт 16. “Цэвэр агаарын сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн судалгаа

Зөвлөмжийн хэрэгжүүлэх байгууллагын нэр	Өгсөн зөвлөмжийн тоо	Зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Хэрэгжилт (тоогоор)			
			100 хувь	70 хувь	40 хувь	хэрэгжээгүй
Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо	5	2019 оны 03/3276, 2021 оны 06/176	1	1		3
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	3			1	2	
Сангийн сайд	2	2020 оны 13-1/8128			2	
Нийслэлийн Засаг дарга (1-р үе шат)	8	2021 оны 2-9	1	3	4	
Нийслэлийн Засаг дарга (2-р үе шат)	8			3	1	4
Нийт	26		2	8	9	7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллагууд холбогдох хууль, журмын дагуу хяналт-үнэлгээ хийсэн байна

2.69. Агаарын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1²⁷-д заасныг үндэслэн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар 2018-2020 онд 352 төлөвлөгөөт, 1166 төлөвлөгөөт бус хяналт шалгалт болон 243 зөвлөн туслах үйлчилгээг хийж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс 969 албан бичиг, 283 өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэн Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 137.5 сая төгрөгийн торгууль ногдуулж, дараах шийдвэрийг гарган, хяналт шалгалтын талаар давхардсан тоогоор 138 мэдээллийг радио, сонин хэвлэл, телевиз, сайт зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажилласан байна. Үүнд:

- *бүтээгдэхүүний 109 дүгнэлт гаргасан,*
- *зөрчил арилгуулах 941 албан шаардлага өгсөн,*
- *үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох, бүтээгдэхүүнийг хураах 124 акт тогтоосон,*
- *68 зөрчлийн хэрэг нээсэн,*
- *271 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн,*
- *зөрчлийн шинжсгүй 48 зөрчлийг татгалзсан,*
- *16 зөрчлийг хэрэгсэхгүй болгосон,*
- *эрх бүхий албан тушаалтанд 322 даалгавар хүргүүлсэн.*

2.70. Мэргэжлийн хяналтын байгууллага дараах байгууллагуудтай хамтарсан шалгалтыг хийхээс гадна Уул уурхай газрын тосны төв лаборатори, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнд сайжруулсан түлш, барьцалдуулагч, түүхий эд, орц найрлагад шинжилгээ хийлгэх зэргээр хамтран ажиллаж байна. Үүнд:

- *Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо,*
- *Байгаль орчин, аялал жуулчлалын яам,*
- *Эрүүл мэндийн яам,*
- *Цагдаагийн ерөнхий газар,*
- *Авто тээврийн үндэсний төв,*
- *Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар,*
- *Эрчим хүчний зохицуулах зөвлөл,*
- *Дүүрэг, хороодын мэргэжилтнүүд.*

2.71. Засгийн Газрын 2018 оны 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, 24 цаг тасралтгүй хяналт тавих ажлыг эрчимжүүлэхийн тулд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос агаар, орчны бохирдлыг хянах ажилд шаардагдах 1 автомашин, 24 таблет, 3 дрон, агаарын бохирдлыг хянах 14 багаж, хэрэгслээр хангах, авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд ажиллах эргүүл, хяналтын ажилтны цалин, урамшуулалд нийт 248.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.

2.72. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн дараах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн байна. Үүнд:

- *Агаарын чанарыг сайжруулах бүст үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд Засгийн Газрын 2018 оны 62 дугаар тогтоол, “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ыг хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэхэд хяналт хийж, 4156 мэдэгдэл, 920 зөвлөмж, 1167 албан шаардлага хүргүүлж, түүхий нүүрс хэрэглэх зөвшөөрөлгүй 75 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 300.1 тонн нүүрсийг дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад буулгуулж, нийт 192.2 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.*
- *Таван толгой түлш ХХК-ийн үйлдвэрлэлийн хүчин чадлын зураглал хийх, бүтээгдэхүүний нөөц, түгээлт, хадгалалт, үйлдвэрлэлийн технологийн процесст хүйтний улиралд 24 цагаар хяналт тавих, сайжруулсан түлшний борлуулалтын цэг, хангамжийн бааз, дундын агуулах үйл ажиллагаа, нөөц*

²⁷ Энэ хуулийн хэрэгжилт, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр батлагдсан нэгдмэл стандартын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

татан авалт, жин хэмжээндээ хурч байгаа эсэх, картаар борлуулж байгаа эсэхэд улсын байцаагч нар байнгын хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах талаарх мэдээллийг удирдлагад хүргэж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

2.73. Засгийн Газрын 2019 оны 158 дугаар тогтоолоор түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон бүсэд урьдчилан сэргийлэх болон хяналтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Эргүүл, хяналт шалгалтын нэгж”-ийг цагдаагийн байгууллагын харьяанд байгуулахаар шийдвэрлэснийг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/116 дугаар тушаалаар “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба”-ыг 58 алба хаагчийн орон тоотойгоор байгуулсан бөгөөд агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2.74. Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга нарын хамтран 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр баталсан удирдамжийн дагуу агаарын чанарыг сайжруулах бүсэд агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглан үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын түүхий нүүрсний хэрэглээ, татан авалт, гэр хорооллын хороодын нутаг дэвсгэрт иргэнд хууль бусаар түүхий нүүрс хэрэглэсэн, хадгалсан эсэхийг айл өрх бүрээр нэг бүрчлэн шалгах арга хэмжээг зохион байгуулсан байна.

2.75. “Түүхий нүүрсний тээвэрлэлт, хэрэглээнд хяналт тавих тухай” Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1118, 2020 оны А/1152 дугаар захирамжийн хэрэгжилтийг авто тээврийн шалган нэвтрүүлэх 3 товчоо, хяналтын 5 цэгт 24 цагаар хяналт, шалгалт хийж, 2019 оны 5 дугаар сараас 2021 он хүртэл зохих зөвшөөрөлгүй тээвэрлэсэн 507.8 тонн түүхий нүүрсийг илрүүлэн улсын байцаагчийн 59 актаар хураан авч, Амгалан дулааны станцад төвлөрүүлсэн байна.

2.76. “Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн Газрын 2020 оны 200 дугаар тогтоолоор сайжруулсан түлшний үнийг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл нийт 75 хувиар хөнгөлснөөр түлшийг хөдөө орон нутагт тээвэрлэх зөрчлүүд гарсан тул Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1285 дугаар захирамжийг үндэслэн хяналт тавин ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Батлан хамгаалах, яам, Гадаад харилцааны яам, Үндэсний хөгжлийн газар, Стандарт, хэмжил зүйн газар, Эрчим хүчний зохицуулах хороо, аймгийн ЗДТГ зэрэг хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлагууд тухайн жилийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгадаггүй байна.
- Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, Нийслэлийн Засаг даргаас бусад хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлагууд тухайн жилийн төсөвт төлөвлөөгүй байна.
- Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргээ биелүүлдэггүйгээс 2020 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 67.8 хувь нь хэрэгжээгүй байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын болон Сангийн яам Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасныг хэрэгжүүлээгүй, холбогдох журам, аргачлалыг боловсруулж гаргаагүйгээс ус бохирдуулсны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх боломжгүй байна.
- Автотээврийн техникийн хяналтын төвүүдэд ашиглагддаг автотээврийн хэрэгслээс агаарт ялгарах нүүрсхүчлийн хийг хэмжигчээр бохирдлыг хувиар тооцдог нь Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад нийцэхгүй байгаагаас утааны ялгаралтын хэмжээг бодитой тодорхойлдоггүй, мөн агаарын бохирдлын төлбөрийг бүртгэлтэй татвар төлөгч бүрт бүрэн ногдуулж, төсөвт төлөвлөж, бүрдүүлдэггүй байна.
- Агаарын чанарын үзүүлэлтүүдээс хүхэрлэг хийн агууламжаас бусад үзүүлэлтүүд суурь түвшнээс буурсан боловч стандарт хэмжээнд хүрээгүй, агаарын бохирдлоос шалтгаалсан өвчлөл 2016 он буюу суурь түвшинд хэвээр байна.
- Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэж буй сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн өртөг зах зээлд борлуулж буй үнээс өндөр байгаагаас улс, орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг, Эрдэнэс Тавантолгой ХК-аас урт хугацааны зээл авч, үйл ажиллагаа явуулсан байна.
- Сайжруулсан түлшний үйлдвэрлэлийн өртгийн 78 хувийг шууд материалын өртөг, 14 хувийг цалин, НДШ-ийн зардал эзэлж байна. Стандартын шаардлага хангасан дотоодын үйлдвэр байхгүй, хүчин чадал хүрэлцэхгүйгээс барьцалдуулагч, түлш савлах 25 килограммын шуудайг ихэвчлэн БНХАУ-аас худалдан авдаг, Тавантолгойн нүүрсний уурхайгаас нүүрсийг машинаар тээвэрлэдэг зэргээс шалтгаалан шууд материалын өртөг өндөр болсон байна.

- Агаарын чанарын бүсэд хамаарах гэр хорооллын зорилтот айл өрхүүд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтөд бүрэн хамрагддаггүй бөгөөд 2017-2020 онд гэр хорооллын айл өрхөд үзүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн 7,319.4 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг хариуцан төлөх байгууллага тодорхой бус байна.
- Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд Тагнуулын Ерөнхий газрын зөвшөөрлөөр зарим худалдан авалтыг төрийн нууцад хамааралтай гэж үзэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасны дагуу шууд гэрээ байгуулж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийсэн нь батлагдсан төсвийг хэмнэлтгүй зарцуулах нөхцөлийг бий болгожээ.
- “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Нийслэлийн Засаг дарга албан ёсоор батлагдаагүй “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-т 2017-2020 онд нийт 9,668.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг нийцүүлэх;

Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д ороогүй бараа, ажил үйлчилгээний худалдан авалтад Тагнуулын ерөнхий газрын зөвшөөрлөөр нууцад хамааруулан зохион байгуулж байгааг хяналттай болгох.

Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргад:

- Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр тайлагнан, хяналт, үнэлгээ хийж, Засгийн газарт танилцуулах, тус хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргээ тогтмол биелүүлж ажиллах;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална” гэж заасны дагуу журам, аргачлалыг баталж, мөрдүүлэх;
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын үр дүнг тогтмол хугацаанд тооцож, чанарын үзүүлэлтийг сайжруулж ажиллах;
- Гэр хорооллын айл өрхөд үзүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн 7,319.4 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах.

Сангийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн жилийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллах;
- Гэр хорооллын айл өрхөд үзүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн 7,319.4 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх.

Эрчим хүчний сайдад:

- Гэр хорооллын айл өрхөд үзүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн 7,319.4 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах;

- Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэлийн өртгийг бодитой бууруулах бүх талын боломжийг судалж, борлуулалтын орлого, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

Татварын ерөнхий газрын даргад:

- Агаарын болон ус бохирдуулсны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх талаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, журам, аргачлалыг боловсруулж мөрдүүлэх.

Эрдэнэс Тавантолгой ХК-д:

- Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэлийн өртгийг бодитой бууруулах бүх талын боломжийг судалж, борлуулалтын орлого, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

Тавантолгой түлш ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

- Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэлийн өртгийг бодитой бууруулах бүх талын боломжийг судалж, борлуулалтын орлого, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад:

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээнд төсөв баталж, санхүүжүүлдэггүй байлгах.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Илэрсэн алдаа, зөрчлийн		Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр	ТЕГ-аас ирүүлсэн албан бичиг
		Тоо	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)		
1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалыг үндэслэн 5 аж ахуйн нэгж, байгууллагатай 3,400.0 сая төгрөгийн 68000 тонн сайжруулсан түлш нийлүүлэх гэрээ байгуулсан байна Гэрээний дагуу 32000 тонн сайжруулсан түлш нийлүүлэх ажлын 30 хувийн урьдчилгаанд нийт 1,100.0 сая төгрөгийг 5 компанид олгосон бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр гэрээний хэрэгжилтийг дүгнэхэд “Усу Коал” ХХК нийт 9000 тонн сайжруулсан түлш нийлүүлэхээс 385 тонныг нийлүүлж, 8615 тонн дутуу нийлүүлсэн буюу 241.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй тул аудитаар албан шаардлага хүргүүлсэн.	1	241.7	Албан шаардлага өгөх	
2	2019 онд "Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лаг, хог хаягдлыг байгальд ээлтэй аргаар шатааж устгах" үйлдвэрийн тоног төхөөрөмжийг 3,500.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулж тоног төхөөрөмжийг 11 дүгээр сарын 21-нээс 12 дугаар сарын 25-ны дотор нийлүүлж суурилуулан туршилтын үйл ажиллагааг эхлүүлэн хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулж урьдчилгаа 60 хувь буюу 2,100.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээний хугацаанд тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлээгүй байна.	1	2,100.0	Зөвлөмж өгөх	
3	2019 онд “Улаанбаатар хотын усан халаалтын бага, дунд оврын халаалтын зуужны утааны хий дэх үнс, тоосонцрыг барих төхөөрөмж худалдан авах, суурилуулах ажил”-ын хүрээнд БНХАУ-ын 3 компаниас нийт 290 ширхэг шүүлтүүрийг 12,029.7 сая төгрөгөөр худалдан авч 9 дүгээр сарын 15-ны дотор хүлээн авч, суурилуулан ашиглалтад бүрэн оруулах ажлыг гүйцэтгүүлэх гэрээг шууд байгуулсан байна. Гэрээний дагуу дээрх 3 компаниас нийт 10,390.6 сая төгрөгөөр 290 ширхэг шүүлтүүрийг авсан гэх боловч албан ёсоор хүлээн авах комисс томилож, хүлээн авч, акт үйлдээгүй, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зуужны ашиглалтын талаарх мэдээлэл хангалтгүй, эд хариуцагч, ажил хариуцсан мэргэжилтнүүдийн шүүлтүүрийн тоо мэдээлэл зөрүүтэй байгаа тул аудитаар албан шаардлага хүргүүлсэн боловч албан шаардлагын хариу хугацаандаа иүүлээгүй тул хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлжээ.	1	10,390.6	Албан шаардлага өгсөн боловч хэрэгжилт ирүүлээгүй тул хуулийн байгууллагад шилжүүлэх	2019.06.14 01/849
4	2017 оны 12 дугаар сарын 25-нд “Баруун Монголын Экологи Төв” төрийн бус байгууллагат агаарын бохирдлыг бууруулах нэгдсэн судалгааны эмхэтгэл ажлын 80 хувь буюу 36.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч ямар ажил хийсэн нь тодорхойгүй, ажлыг дуусгаж хүлээж аваагүй, одоогийн байдлаар хэн хариуцаж дуусгах нь тодорхойгүй байна.	1	36.0	Зөвлөмж өгөх	
5	2019 онд агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах дэвшилтэт техник, технологи инновацыг дэмжих, урамшуулах” ажлын хүрээнд Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төслийг 800.0 сая төгрөгөөр 9 дүгээр сарын 2-ноос 11 дүгээр сарын 23-ны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөж, гэрээний дагуу 70 хувийн санхүүжилт болох 548.8 сая төгрөгийг шилжүүлсэн боловч тус компани ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг бүрэн хийгээгүй тул үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй байна.	1	548.8	Зөвлөмж өгөх	2019.08.07 01/1085
6	Дархан-Уул аймагт 246 ширхэг зуужны төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан боловч төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилж 3190 ширхэг 335.4 сая төгрөгийн цахилгаан халаагуурыг гэр хорооллын айл өрхүүдэд тараасан байна.	1	335.4	Зөвлөмж өгөх	
7	Ховд аймагт агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөө ирүүлээгүй байхад 800.0 сая төгрөгийг шилжүүлсэн, агаарын бохирдлыг бууруулахтай холбоогүй 36 айлын хашааны хаалгыг сайжруулж, жигдрүүлэх, барилгын зураг төсөл зэрэг ажилд 116.0 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	800.0	Зөвлөмж өгөх	
8	2020 онд БНХАУ-ын Hebei Yonghua environmental Protection equipment ХХК-ийн Монгол улс дахь төлөөлөгч “Кан Мэй Хуан Бао” ХХК-тай Хөвсгөл, Увс, Ховд, Орхон аймгийн дулааны станцад шүүлтүүр суурилуулахаар тус бүр нь 750.0 сая төгрөг нийт 3,000.0 сая төгрөгийн өртөгтэй шүүлтүүрийг нийлүүлэхээр гэрээг байгуулж, урьдчилгаа 1,800.0 сая төгрөгийг олгосон боловч хөрөнгийг хүлээлгэж өгөх комисс томилогдоогүй, гэрээг дүгнээгүй ашиглалт хангалтгүй, Орхон аймгийн шүүлтүүрийн зориулалтыг өөрчилсөн байна.	1	1,800.0	Зөвлөмж өгөх	
9	2019 онд ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнд 28 нэр төрлийн хийн шинжилгээний багажуудыг 292.0 сая төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн боловч гэрээнд нийлүүлэх хугацааг тодорхой тусгаагүй бөгөөд одоог хүртэл нийлүүлээгүй байна.	1	292.0	Зөвлөмж өгөх	2019.12.16 01/1703
10	2019 онд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэнд 138.0 сая төгрөгийн "Таван толгой түлш" ХХК-ны 504 борлуулалтын цэгээс түүвэрлэн сайжруулсан түлшний дээж авч чанарын хяналт, шинжилгээ, судалгаа хийхээр гэрээ байгуулсан боловч хэзээ эхэлж дуусгах мөн хэнд зориулж хийгдсэн нь тодорхойгүй байна.	1	138.0	Зөвлөмж өгөх	
11	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2019-2021 онд сайжруулсан ариун цэврийн байгууламжийг туршиж, 1440-аас доошгүй өрхөд суурилуулан байхаар тусгасан . Тус ажлыг гүйцэтгэж байгаа гүйцэтгэчийн ажилд захиалагчийн хяналт тавихгүй байна.	1	57.0	Албан шаардлага өгөх	
Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дүн		11	16,739.5		

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№	Алдаа, зөрчлийн товч утга	Илэрсэн алдаа, зөрчлийн		Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр	ТӨГ-аас ирүүлсэн албан бичиг
		Тоо	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)		
12	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн А/750 тушаал, Нийслэлийн Засаг даргын 11 дүгээр 25-ны өдрийн А/1245 тоот захирамжаар угаарын хий мэдрэгч 200,000 ширхэг төхөөрөмжийг БНХАУ-ын "PGST" ХХК-тай шууд гэрээ байгуулан 3512.0 сая төгрөгөөр худалдан авч нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд үнэ төлбөргүй тараасан боловч манай улсад мөрддөг стандарт байхгүй, үнийн судалгаа хийгээгүй байна.	1	3,512.0	Зөвлөмж өгөх	
13	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/864 тоот захирамжаар "Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийслэлийн гэр хорооллын айл өрхийн сайжруулсан түлшний нөөцлөхөд шаардлагатай агуулах түрээслэх" ажлыг зохион байгуулж, 35 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай түрээсийн гэрээ шууд байгуулж 7 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1-ний хооронд 1м2 талбайн түрээсийг хотын төв, төвөөс алслагдсан байдал зэргийг харгалзан 6000-8000 төгрөгийн хооронд тогтоож түрээсийн төлбөрт 1,391.8 сая төгрөгийг төлсөн байна.	1	1,391.8	Зөвлөмж өгөх	
14	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Цэвэр агаартай хот аяныг зохион байгуулах тухай" А/1332 дугаар захирамжийг үндэслэн агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлын 210.0 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг Соёл урлагийн газарт шилжүүлж хөрөнгийг зориулалт бус зарцуулсан тул аудитаар албан шаардлага хүргүүлсэн.	1	210.0	Албан шаардлага өгөх	
15	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн А/781 дугаар тушаалаар Нийслэлийн 6 дүргийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 95 хорооны орон тооны бус ажилчдыг урамшуулах, байгальд ээлтэй дэвшилтэт технологи ашиглан халаалт, гэр байшингаа дулаалсан шилдэг өрхийн шагналд 125.0 сая төгрөг шилжүүлж үүнээс гэр байшингаа дулаалсан шилдэг айл өрхөд 19.0 сая төгрөг олгож, үлдсэн 106.4 сая төгрөгийг Манжуур хотын аялалд аялуулахаар төлөвлөсөн боловч цар тахал гарч хил хаагдсантай холбоотой аялал жуулчлалын үйл ажиллагаа зогссож тул буцаан төвлөрүүлсэн байна.	1	125.0	Зөвлөмж өгөх	
16	"Утаагүй Улаанбаатар хөтөлбөр" батлагдаагүй боловч тус батлаагүй хөтөлбөрт санхүүжилт баталж хэрэгжүүлж ирсэн байна.	1	9,668.7	Зөвлөмж өгөх	
Нийслэлийн дүн		5	14,907.5		
17	Шөнийн тарифт тоолууртай гэр хорооллын айл өрхүүдэд 2017-2020 онд хөнгөлөлтөд 47,673.4 сая төгрөг олгохоор тооцож, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 40,354.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж үлдэгдэл 7,319.4 сая төгрөгт санхүүжилт хийгдээгүй буюу өртэй гарсан байна.Хуримтлагдсан 7,319.4 сая төгрөгийн өр төлбөрийг Эрчим хүчний яам болон Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны аль байгууллага нь хариуцаж төлөх нь тодорхой байна.	1	7,319.4	Зөвлөмж өгөх	
18	Таван толгой түлш ХХК-д гэрээтэй ажилладаг борлуулагч нарын НДШ-ийн Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газрын төсөвт байхгүйгээс 2019 онд 256.2 сая төгрөг, 2020 онд 778.0 сая төгрөг нийт 1,034.2 сая төгрөгийн өр үүсэн тул энэ өр төлбөрийг хэрхэн яаж барагдуулахыг Таван толгой түлш ХХК болон Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газрын аль байгууллага нь хариуцаж шийдвэрлэхийг одоогоор шийдээгүй байна.	1	1,034.2	Зөвлөмж өгөх	
19	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 5 байршилд сайжруулсан түлшний агуулах барих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нийслэлийн төсөвт тусгахдаа магадлалаар баталгаажуулаагүй 750 сая төгрөгөөр тусгаж 5 аж ахуй нэгжтэй Нийслэлийн засаг даргын тамгын газар дээр шууд гэрээ байгуулсан байна. Ингэхдээ Ерөнхий сайдын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Энх-Амгалангийн 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн №231 тоот албан бичгийн хариугаар ирсэн Тагнуулын Ерөнхий газрын 2019 оны 3 дугаар сарын 25-ний өдрийн 01/414 тоот албан бичгээр тус арга хэмжээний гүйцэтгэлийг сонгон шалгаруулах ажиллагаа нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.3.4, Үндэсний аюулгүй байдлын 2017 оны 03/03 дугаар зөвлөмжид хамааралтай тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4 -д заасны дагуу шууд гэрээ байгуулах тухай уламжилсанаар НЗДТГ-аас "Евро азиа констракшн" ХХК-тай 748,253,000 төгрөг, "Хүннү гүрэн констракшн" ХХК-тай 748,000,000 төгрөг, Гранд-Интернэйшнл ХХК-тай 740,000,000 төгрөг, "Ган алт нэмэх" ХХК, "Нумт Өргөө" ХХК-иудтай тус бүр 750,000,000 төгрөг, нийт 3,724,312,315 төгрөгийн шууд гэрээ байгуулан ажилласан байна.	1	3,724.3	Зөвлөмж өгөх	2019.03.25 01/414
Дүн		3	12,077.9		
Нийт дүн		19	43,724.9		

Хавсралт 2. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжээгүй арга хэмжээний жагсаалт

Д/д	Заялтын дугаар	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Тайлбар
1	1.1.1	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	15 аймгийн хэмжээнд ерөнхий төслийг боловсруулсан байна.	БХБЯ	Хэрэгжилт ирүүлээгүй
2	1.3.1	Нүүлгэн шилжүүлэх, дахин төлөвлөх эрхэйн орчныг бүрдүүлэх	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох шийдвэр	2. Ачаа тээврийн төмөр зам байгуулах, арьс шир, ноос ноолуур болон бөхирдөл ихтэй бусад үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг холбогдох байгууллагаар гаргуулсан байна.	НЗДТГ	Ачаа тээврийн төмөр зам баригдаагүй, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг нийслэлээс гаргах арга хэмжээ үр дүнгүй буюу хэрэгжээгүй. Нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин бүрдүүлээгүй тул хэрэгжээгүй байна.
3			Хот, суурин газрыг дахин төлөвлөх тухай хууль, түүнийг дагалдан гарах дүрэм, журам, заавар, аргачлал	Хууль, дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулан батлуулсан байна.	БХБЯ	Хэрэгжилт ирүүлээгүй
4	1.3.2	Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болгох "Ухаалаг" жишиг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	Жишиг "Ухаалаг" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	Жишиг "Ухаалаг" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	БХБЯ	Хэрэгжилт ирүүлээгүй
